



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-12
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-53
<hr/>	
1.Хуулийн төслийг эцэслэн батлах	15-16
2.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	16-17
3.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	18-20
4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	21-22
5.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2025.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	23
6.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-51
7.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох	52-53

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
05 дугаар сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Л.Мөнхбаясгалан, Б.Найдалаа, Р.Сэддорж, Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Л.Гантөмөр, Ц.Идэрбат, М.Мандхай, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, А.Ундраа, Н.Учрал, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, Ж.Ганбаатар, П.Мөнхтулга, Б.Тулга, С.Цэнгүүн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Т.Аубакир, Д.Батлут, А.Ганбаатар, Д.Пүрэвдаваа.

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-01 минут, Д.Амарбаясгалан-37 минут, С.Амарсайхан-37 минут, О.Амгаланбаатар-02 минут, Ч.Анар-29 минут, Ж.Батсуурь-11 минут, Н.Батсүмбэрэл-11 минут, Ж.Баярмаа-22 минут, Г.Ганбаатар-17 минут, Д.Ганбат-17 минут, М.Ганхүлэг-02 минут, Г.Дамдинням-22 минут, Б.Жавхлан-1 цаг 46 минут, Х.Жангабыл-03 минут, Д.Жаргалсайхан-37 минут, Ж.Золжаргал-37 минут, Н.Наранбаатар-04 минут, М.Нарантуяа-Нара-06 минут, Ч.Номин-18 минут, О.Номинчимэг-11 минут, С.Одонтуяа-01 минут, Б.Пунсалмаа-11 минут, О.Саранчулуун-07 минут, Г.Тэмүүлэн-09 минут, Ж.Чинбүрэн-08 минут, Б.Энхбаяр-08 минут, Ж.Энхбаяр-40 минут.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр нарын 6 гишүүнээс 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2026.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслүүдтэй

холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

3.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүнээс 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүнээс 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:10/

### ***Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам байлцав.

**С.Бямбацогт:** 1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 6  
Бүгд: 80

92.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийг дэмжсэнээр тооцож, 93.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**С.Бямбацогт:** 2.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 7  
Бүгд: 81

91.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа нар байлцав.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:**

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Н.Алтаншагай, Д.Бум-Очир, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Г.Хосбаяр, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 32  
Бүгд: 81  
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун саналаа тайлбарлав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 22  
Бүгд: 81  
72.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг дэмжсэнээр тооцож, 74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Н.Монголмаа нар байлцав.

*Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/*

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль,” гэснийг хасаж, мөн хэсгийн “Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэсний дараа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 13  
Бүгд: 84  
84.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах,  
урамшуулах, дэмжлэг үзүүлэх**

19.1.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагаанд сайн дурын ажилтан, иргэн оролцож болно.

19.4.Цусны байнгын донорт цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу энэ хуулийн 10.2.10-т заасан тэмдгийг олгоно.

19.5.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.5.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.2.цусаа 35 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн.

19.6.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.7.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.8.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулах бөгөөд холбогдох журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.9.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор аймаг, нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчино.

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.8, 19.9-д заасан дэмжлэг хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 10

Бүгд: 84

88.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 17

Бүгд: 86

80.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.4 дэх хэсгийн “сан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай” гэснийг “эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах:

“25.3.Энэ хуулийн 25.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагаа нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 16  
Бүгд: 86  
81.4 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа нар байлцав.

*Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/*

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 23  
Бүгд: 86  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Пунсалмаа, Г.Очирбат нарыг дэмжсэнээр тооцож, 76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 22  
Бүгд: 87  
74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоногийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 24  
Бүгд: 87  
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Ц.Мөнхтуяа нарыг дэмжсэнээр тооцож, 74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгах санал:*

**С.Бямбацогт:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 22  
Бүгд: 87

74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав.** *“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2025.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

*“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.*

**С.Бямбацогт:** “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 19

Бүгд: 87

78.2 хувийн саналаар дэмжигдлээ.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдааныг Төсвийн байнгын хороо хуралдаж дуустал 10 цаг 40 минутас 11 цаг 03 минутад түр завсарлуулав.*

**Зургаа.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга

Ч.Хишигдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Х.Тэмүүжин, Ө.Шижир, Ц.Баатархүү, Б.Пүрэвдорж, М.Бадамсүрэн, Н.Алтаншагай, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, А.Ариунзаяа, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Г.Ганбаатар нар үг хэлэв.

**С.Бямбацогт:** Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 23  
Бүгд: 93  
75.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Долоо.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:42/

***Дагалдан гарсан:***

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:42/

3.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:43/

4.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:43/

5.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:44/

6.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:44/

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.*

**Бусад.**Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 12<sup>Г</sup> ангийн багш, сурагчид, Монгол-Солонгосын Политехникийн коллежийн Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн урилгаар “Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал хөтөлбөр”-ийн оролцогчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Н.Батсүмбэрэл нарын урилгаар Чингэлтэй дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын урилгаар Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургуулийн 12<sup>Д</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн урилгаар Баянзүрх дүүргийн Ардчилсан намын хорооны гишүүд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 19 минут үргэлжилж, 126 гишүүнээс 93 гишүүн хүрэлцэн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 45 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,  
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 03 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Чуулганы хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн буюу 50.8 хувь ирц хүрсэн байна. 2026 оны 5 сарын 15-ны өдрийн Баасан гарагийн нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ.

7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай бас мэдээлэл гишүүддээ өгье. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2026 оны 5 сарын 7-нд өргөн мэдүүлсэн, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бас Засгийн газар 2026 оны 5 сарын 7-нд өргөн мэдүүлсэн, ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Хувь хүний орлогын албанд Засгийн газар 2026 оны 5 сарын 7-нд өргөн мэдүүлсэн, ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 3 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэ хуулиудыг Төсвийн байнгын хороогоор энэ 7 хоногт хэлэлцэх байсан. 5 сарын 13-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарын гаргасан горимын санал дэмжигдэж хойшлуулсан тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан гэдгийг та бүхэндээ мэдээлэл болгож хэлье.

Мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Энэ асуудал дээр Төсвийн байнгын хорооны 5 сарын 13-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг ажлын 4 өдрийн завсарлага авсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан байна аа.

Энэ 7 хоногт энэ өдрүүдэд бас гэр бүлийн өдөр болж байгаа. 5 сарын 15-ны өдөр жил бүрийн 5 сарын 15-ны өдөр гэр бүлийн өдөр болдог оо. Тэгээд Монгол гэр бүл бол Монгол Улсын үндэс гэр бүлийн өдөр бас тохиож байна аа. Мөн Үндэсний бичиг соёл номын өдрүүд жил бүрийн 5 дугаар сар болон 9 дүгээр сарын 3 дахь 7 хоногийн бямба, ням гарагт болдог. Өнөөдөр бас Сүхбаатарын талбай дээр бас номын өдрүүд зохион байгуулагдаж байгаа. Манай Их Хурлын гишүүд энд Лодойсамбуу гишүүн нар маань бас номын өдрүүд бас номын нээлт баяраа бас хийж байгаа. Тэгээд олон гишүүддээ бас номын баяр хийж байгаа гишүүддээ баяр хүргэе ээ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрүүд жил бүрийн бас 5 дугаар сарын 3 дахь бямба гарагт бас болдог оо. Тэгээд хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын нийт ажилтан албан хаагч нартаа бас мэндчилгээ дэвшүүлье ээ Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс.

Өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд эртэч 5 гишүүнээ танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Мягмардашийн Сарнай, Буланы Бейсен, Лутаагийн Энхнасан нарын гишүүд маань эртэч гишүүд болжээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 7 асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Төсвийн байнгын хороо дуусаж уу? Төсвийн байнгын хорооны гишүүд одоо тэгвэл орж ирээд энэ хуулийн төслүүдийг эцэслэн батлахад оролцчихвол их зүгээр байна. 64 гишүүнээр батлагдах ёстой.

Тэгээд 2 дахь асуудал Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Гуравдугаарт, Цусны донорын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Дөрөвдүгээрт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Тавдугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна.

Эдгээр асуудлууд бол өчигдөр асуулт асуугаад хариултуудаа авчихсан. Дандаа санал хураалтууд байгаа. Гишүүдийг бас санал хураалтууддаа танхимдаа бас хариуцлагатай оролцохыг санал хураалтад оролцохыг хүсэж байна.

Зургаад нь, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлээд явуулна. Засгийн газар хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн.

Долоод нь, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно оо. Ийм 7 асуудал өнөөдөр хэлэлцэх нь байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр нарын 6 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд.

3. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 7 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваариллаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төсвийн байнгын хорооны гишүүд ороод ирсэн үү? Төсвийн байнгын хороонд байж байгаа гишүүд хуулийн төсөл эцэслэн баталж хүрэлцэн ирнэ үү.

### **Хуулийн төсөл эцэслэн батлах**

Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батална аа.

Хууль тогтоолын төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүд бэлдэнэ үү. Танхимд 70 гаран гишүүн байх шиг байна тийм үү? Санал хураалтад 64 гишүүн бэлэн болсон байна. Бусад гишүүд бэлэн болно уу.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ.

Санал хураалтаа явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалтад 80 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 92.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Батсүмбэрэл гишүүнийг дэмжсэнд тооцож оруулъя. 75 гишүүн болж байна.

2.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 91.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье ээ. Их чухал хууль батлагдсан. Эд эрхтэн, эд эс шилжүүлэх.

10.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

### ***Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг***

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо байнгын хорооноос санал хураалгахаар бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсвэл эсрэг байр суурьтай намын бүлэг эсвэл аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагддаг 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо.

Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгээс гэсний дараа тэр үед 3 хүртэлх насанд нь гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун, Алтаншагай, Бум-Очир, Ганмаа, Ганхүлэг, Мөнхтуяа, Сарнай, Хосбаяр, Энхнасан. Цаашид ажлын хэсэг гэх.

Саналаа тайлбарлаж Бадамсүрэн гишүүн л үг хэлэх юутай байгаа. Ажлын хэсгийн ахлагч Отгоны Саранчулуун гишүүн ажлын хэсгийн ахлагч мэдээлэл өгье гишүүддээ.

**О.Саранчулуун:** Гишүүд ээ, ийм байгаа. 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхдийг тооцдоггүй байгаа нэг ийм асуудал байгаа. Энэний цаана юу вэ гэхлээр насан туршдаа тэр хүүхэд бол тэр айлын гэр бүлийн гишүүн байхгүй юу. Энийг дагаад тэтгэвэрт эрт гарах үндэслэл үүсэж магадгүй гээд байгаа юм. Энэ дээр болохоор тэр насыг нь одонгийн асуудал дээр бид нар насыг нь арилгаж байгаа. Хүүхэд л бол хүүхэд тиймээ. Одоогийн байдлаар 10 наснаас дээш хүүхэд 207 байгаа үрчлүүлсэн хүүхдүүдийн тоогоор харах юм бол 10-аас дээш настай хүүхдүүд. Ер нь бол хүмүүс юу гэдэг юм тэтгэвэр авахын тулд ч юм уу, ямар нэгэн мөнгө авахын тулд ингэж хүүхэд үрчилж авах тохиолдол нь одоо байгаа тоогоор биш байгаа. Ямар хүүхдүүд үрчлэгдээд байгаа гэхлээр ээж аав нь нас барсан үнэхээр одоо өнчин өрөөсөн хүүхдүүд л үрчлэгдэж байгаа шүү дээ.

Тэгээд дээрээс нь өөрөө 2, 3 хүүхэдтэй байж байж дахиад нэг хүүхдүүдийг 1, 2 хүүхэд үрчилж авна гэдэг тийм тохиолдлыг харах юм бол их цөөхөн байгаа. Тэгэхлээр та хэд ойлгоорой. Хүүхэд нэмж үрчилж аваад тэтгэвэр авах эрх үүсэхгүй. Яагаад гэвэл тэтгэврийн тухай НДШ-ийн тэтгэврийн тухай хууль дээр 3 хүртэлх нас гэдэг нь хэвээрээ үлдэнэ гэсэн үг. Тэгэхээр энийг л би нэмж тайлбарлах гээд байгаа юмаа.

**С.Бямбацогт:** Санал ажлын хэсэг тайлбарлалаа. Гишүүд бас ойлголттой болсон байх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 49 гишүүн буюу 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө өө. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 72.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Эх үрсийн баярын өмнө бид нар бас чухал хуулиа хэлэлцлээ. Ирэх 7 хоногт эцэслэн эцсийн хэлэлцүүлгээ яваад эцэслэн баталчихъя. Манай ажлын хэсэг байнгын хороо бас анхааралдаа авч ажиллаарай. Эх үрсийн баярын өмнө бас манай эхчүүд хүүхдүүдэд бас томоохон бэлэг болох байх аа. Батчимэг гишүүнийг дэмжсэнд тооцъё түрүүн санал хураалт дээр.

Дараагийн асуудал.

***Цусны донорын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг  
/үргэлжилнэ/***

Цусны донорын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асууж хариулт авч дууссан. Одоо байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж эсвэл аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагддаг тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Цусны донорын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал. Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн санал тийм ээ.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль,” гэснийг хасаж, мөн хэсгийн “Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэсний дараа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 84 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 84.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах,  
урамшуулах, дэмжлэг үзүүлэх**

19.1.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагаанд сайн дурын ажилтан, иргэн оролцож болно.

19.4.Цусны байнгын донорт цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу энэ хуулийн 10.2.10-т заасан тэмдгийг олгоно.

19.5.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.5.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.2.цусаа 35 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн.

19.6.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.7.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.8.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулах бөгөөд холбогдох журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.9.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор аймаг, нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчино.

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.8, 19.9-д заасан дэмжлэг хамаарна.”

Санал гаргасан Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 84 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 88.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ЕБС-ийн 50 дугаар сургуулийн Сарангоо багштай 12-ын “г” ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье ээ. Удахгүй дунд сургуулиа төгсөнө. Төгсөөд хүссэн мэргэжлээрээ хүссэн их дээд сургуульдаа элсэн орж сайн мэдлэг боловсрол эзэмшсэн эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан хариуцлагатай хуулиа дээдэлдэг иргэн болоорой. ЧД-ийн сургууль. Алдаржавхлан гишүүн, манай Эрдэнэболд гишүүдийн төгссөн сургууль байна шүү бас.

Дараагийн санал хураалтдаа оръё.

3.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.” Санал гаргасан Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 80.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.4 дэх хэсгийн “сан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай” гэснийг “эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах:

“25.3.Энэ хуулийн 25.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагаа нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 81.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Цусны донорын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдөр бас энэ чухал хуулийг бид бас эцсийн хэлэлцүүлэг хийж байна. Монгол Улсын хэмжээнд 210 мянган донор тогтмол цусаа хандивладаг юм байна лээ. Нэг иргэний хандивласан цус 3 хүний амийг авардаг гэсэн эрүүл мэндийн байгууллагын судалгаа байдаг. Энэ хуулийн төсөл төслийн ач холбогдол нь бол ямар нэгэн хариу нэхэлгүй сайн санаа, сайхан сэтгэлийн үндсэн дээр хүний алтан амийг аврах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулж цусаа хандивладаг иргэдээ алдаршуулах, сайн дураар цусаа хандивлах донор эгнээг өргөжүүлэх үйлийг бодитоор дэмжих ийм ач холбогдолтой. Өнөөдөр бас манай энэ танхимд Аюушийн Ариунзаяа, Жигжидийн Батжаргал, Мөнгөнсүхийн Ганхүлэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Ганбатын Хосбаяр, Ухнаагийн Отгонбаяр, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ганзоригийн Тэмүүлэн нарын гишүүд маань тогтмол цусаа хандивлаж, хамгийн доод тал нь 10 удаа, дээд тал нь 50 удаа бас цусаа хандивлаж эрдэнэт хүний бас амь насыг аврах үйлсэд нэгдсэн байгаа. Энэ гишүүддээ бас Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс талархлаа илэрхийлье ээ.

10.30 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

***Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг /үргэлжилнэ/***

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна аа. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагддаг тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо. Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар БОХХАА-н байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал. Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.” Санал гаргасан БОХХАА-н байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Булгантуяа гишүүнийг дэмжсэнд тооцъё. Пунсалмаа гишүүн, Очирбат гишүүдийг бас дэмжсэнд тооцъё оо. 66 гишүүн болж байна дэмжсэн.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.” Санал гаргасан БОХХАА-н байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 74.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Монгол Солонгосын Политехник коллежийн Мөнхбат багштай Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Төрийн ордонд зочилж байгаа дүү нартаа бас Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе ээ. Та бүхэн бол одоо Монгол Улсынхаа шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэж, нийгмийг өөрчлөх хамгийн хүчтэй хөдөлгүүр гэдгээ санаж, илүү идэвхтэй ажиглагч биш оролцогч байгаарай. Нийгмийнхээ үйл хэрэгт.

Дараагийн санал хураалт.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоногийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.” Санал гаргасан БОХХАА-н байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 63 гишүүн Номин гишүүн дэмжсэнээр тооцъё, Мөнхтуяа гишүүнийг дэмжсэнээр тооцъё, 65 гишүүн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураалгасан санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” Санал гаргасан БОХХАА-н байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Энийгээ би хэлчихсэн тиймээ.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 74.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар БОХХАА-н байнгын хороонд шилжүүлээ.

10.37 цаг

***“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх /үргэлжилнэ/***

Дараагийн асуудалдаа оръё.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачилсан илтгэл, тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн байна.

Саналын томъёолол санал хураалт. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 78.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.40 цаг

Дараагийн асуудал.

***Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл***

Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл байгаа. Төсвийн байнгын хороо яг энэ цаг үед хуралдаж байна. Тийм болохоор чуулганы хуралдааныг нэг цаг завсарлуулчих уу. 11:30-аас хуралдаан танхимдаа хүрэлцэн ирэхийг гишүүддээ урья аа. Түр завсарлая.

ЗАВСАРЛАГА

**С.Бямбацогт:** Чуулганаа нээчих үү. Дараагийн асуудалдаа оръё.

Төсвийн байнгын хороо хуралдаж дуусаад санал, дүгнэлт бэлэн болсон байна. Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна аа. Их Хурлын гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна аа. Индэрт урьж байна.

**З.Мэндсайхан:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээ хэлэлцээр бүхий гадаад зээлийн төслийн эх үүсвэрүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тэр дундаа үндэсний аюулгүй байдлыг хангах, стратегийн төслүүдийг хугацаанд нь ашиглах, ашиглалтад оруулах зорилготой Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэж Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дэмжсэн болно оо.

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш нийт 308 төсөл арга хэмжээнд 10.4 тэрбум ам.доллар буюу 33.4 их наяд төгрөгийн төслийн зээлийн хэлэлцээр байгуулснаас өнөөдрийн байдлаар 6.1 тэрбум ам.доллар буюу 19.6 их наяд төгрөгийн хөрөнгийг ашиглаж, 4.3 тэрбум ам.доллар буюу 13.8 их наяд төгрөгийн ашиглаагүй үлдэгдэл байгаагийн 38 хувь нь буюу 5.3 их наяд нь газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслүүдийн үлдэгдэл санхүүжилт байна аа.

Мөн хэрэгжиж буй төслүүдийн 68 хувь буюу 52 төсөл нь хөнгөлөлттэй, 32 буюу 22 төсөл нь нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр хэрэгжиж байгаагаас гадна зарим төслүүд нь зээлийн эх үүсвэрийг дагасан тусламжийн санхүүжилтийг тодотгох нь зүйтэй байна аа. Нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын төсөвт ирэх шууд ачааллыг бууруулж, дунд болон урт хугацааны хөгжлийн суурийг тавих чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа хэдий ч 2011 оноос нэн хөнгөлөлттэй нөхцөл өөрчлөгдөж, Монгол Улс энгийн болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах болсон. Харин 2024 оноос эхлэн манай улс дунджаас дээгүүр орлоготой улс болсон тул арилжааны нөхцөлтэй зээл авахаар зээлийн нөхцөл өөрчлөгдөж байна аа. Нийт зээлийн төслүүдийн 13.8 их наяд төгрөгийн ашиглагдаагүй үлдэгдлийн 89 хувь нь 2026-2029 онд хэрэгжиж дуусах гэрээ хэлэлцээртэй байгаа нь ирэх 3 жилд зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл бөгөөд зээлийн ашиглалтыг Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаанд багтаан хэрэгжүүлэхгүй тохиолдолд төслийн хугацаа хойшлох, өртөг өсөх, хүүгийн болон үйлчилгээний зардал нэмэгдэх улмаар хөрөнгө оруулалтын төслүүд хугацаанд ашиглалтад ороогүйгээс үүдэн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр өгөөж саарах бодит эрсдэлийг бий болгож байна аа.

Нөгөө талдаа Улсын Их Хурлаар соёрхон баталсан гэрээ хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуульд зааснаар олон улсын гэрээнд хамаардаг бөгөөд энэ

үүднээсээ олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улс, санхүүгийн байгууллагаас тогтмол хийгддэг үнэлгээнд нөлөөлөх асуудал юмаа.

Өнөөдрийн төсвийн хязгаарлалттай нөхцөл байдлаас шалтгаалж гадаад зээлийн эх үүсвэртэй төслүүдийн гэрээний дагуух шаардлагатай санхүүжилтийн дөнгөж 22 орчим хувийг улсын төсөвт тусгаж байгаа нь хэрэгжилтийн гол хүндрэл болж байна. Хэрэв зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхгүйгээр энэ түвшин хэвээр үргэлжилбэл зарим төслүүдийн хэрэгжилт дунджаар 5-10 жилээр хойшлох, зардал нэмэгдэх, өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх бодит эрсдэл үүссэн. Хэдийгээр энэ онд 18 төсөл хэрэгжиж дуусаж байгаа боловч шинээр эхлэх төслүүдийн гэрээтэй холбоотойгоор зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл ирэх онуудад өндөр хэвээрээ байх хандлагатай байна аа.

Иймд Улсын Их Хурал Засгийн газрын түвшинд гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын болон эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох шаардлага үүссэн тул Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна аа.

Хуулийн төсөл нь 4 бүлэг, 5 зүйлтэй бөгөөд хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг, 2 дугаар бүлэгт гадаад зээлийн ашиглалтын зардлын зохицуулалтыг, 3 дугаар бүлэгт гадаад зээлийн ашиглалтын ил тод байдал, хяналтын асуудлыг, харин 4 дүгээр бүлэгт хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг тус тус тусгалаа.

Хуулийн төсөл нийт хэрэгжиж байгаа төслүүдээс гадна газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдийн хүрээнд ашиглалтыг нэмэгдүүлэхийг тодорхой тусгаж өгсөн бөгөөд хууль өөр төсөл нэмж тусгах төслийн нэр өөрчлөхийг хориглосон. Түүнчлэн хуулийг эдгээр төслүүдийн зээлийн ашиглалт бүрэн дуусах хүртэл хүчин төгөлдөр байхаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар 2026 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд 1.5 их наяд төгрөг, Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн хувьд 324.1 тэрбум төгрөгийн ашиглалт буюу нийт 1.8 их наяд төгрөгийн санхүүжилт гарснаар төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хэлэлцээрийн хугацаанд багтаан ашиглалтад оруулснаар зээлийн үйлчилгээний төлбөр тэр дундаа хөрөнгө баталгаажуулсны төлбөр төлөгдөх 104.1 тэрбум төгрөгийг хэмнэх нөхцөлийг бүрдүүлнэ ээ.

Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын хэрэглээний 55 хувийг хангаж, жил бүр 1 тэрбум долларыг дотооддоо үлдэх, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын хувьд баруун бүсийг 100 хувь эрчим хүчээр хангаж жил бүр 17.5 тэрбум төгрөг дотооддоо үлдэж, импортын цахилгаан эрчим хүчийг орлохоор байна аа.

Иймд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Төсвийн талаарх төрийн төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Нанзадын Наранбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Н.Наранбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого зорилтууд эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, импортыг орлох үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд хэрэгжих гадаадын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслүүдийн гадаад зээлийн ашиглалтыг холбогдох гэрээ хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж төсөл санаачлагч үзсэн байна. Хуулийн төслийг 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Д-парламент цэг мн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна аа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг өргөн мэдүүлсэн төсөлд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хассанаар өмнө өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслүүдэд өөрчлөлт орсон эсэх талаар асуулт асууж, өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахгүйгээр батлах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт ЭХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Уранбаатарын Чинзориг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Гэрээ эрх зүйн газрын дарга.

Ажлын хэсэгт хууль сануулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д Засгийн газрын гишүүн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25.Хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд төрийн албаны болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа. Тэгэхээр Их Хурал дахь хүндэтгэлтэй хандахыг мөн бас үнэн зөв бодитой мэдээлэл өгөхийг ажлын хэсгийн гишүүддээ сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

**Г.Хосбаяр:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Энэ өмнө нь орж ирээд дэмжигдээгүй энэ хуулийн төслийг бас өмнө нь дэмжиж байсан. Яагаад дэмжсэн бэ гэхээр энэ Монгол Улс маань бас нэн хөнгөлөлттэй, урт хугацаатай бас нэлээд их зээлийн хэлэлцээрийг бас олон жилийн өмнөөс хийчихсэн юм байна лээ. Тэгээд энэ хуулийн энэ зээллэгүүдээ авч ашиглаад, энэ бүтээн байгуулалтуудаа хурдан хийгээд дуусгая гэхээр бас энэ хуулийн хязгаар, өрийн хязгаар юмнууд маань ингээд тулчхаад байдаг. Гэтэл нөгөө талд нь дэлхий нийтээрээ бүтээн байгуулалтын зардал өсөж байна аа. Дэлхийн аль ч улсад зам барилга, эрчим хүч, шинэ бүтээн байгуулалтууд жилд дор хаяж 5-10 хувийн өсөлттэй явж байна аа.

Тийм учраас бид нар энэ хэлэлцээр хийчихсэн, одоо авахад бэлэн байгаа энэ зээлийн ашиглалтаа бол бүгд заавал энд 2 төсөл энэ тодорхой нэр заасан төслүүд дээр хязгаарлахгүйгээр бүгдийг нь шуурхай явуулж, авч ашиглаж энэ улс орныхоо бүтээн байгуулалтыг эрчимжүүлмээр байна аа. Тэгэхгүй бол одоо урьд түрүүчийн 7 хоногт төсвийн төсөөлөл ярьсан, хөгжлийн төлөвлөгөө ярьсан. Энэ төсвийн төсөөлөл хөгжлийн төлөвлөгөөгөөр ирэх жилүүдэд бас хөрөнгө оруулалт яг улсын төсвийн хөрөнгө оруулалт нэлээд багасах ийм төсөөлөлтэй байгаа.

Тийм учраас энэ манай улс чинь дэд бүтцийн хөгжлийн хувьд хэдэн зуу дахин хоцрогдчихсон улс явж байна шүү дээ. Тэгэхээр бид нар энэ замаа, энэ өргөн уудам нутагтаа замаа баримаар байна. Шугам сүлжээгээ хиймээр байна, ажил хиймээр байна аа. Тэгээд ажил хийхийн тулд ингээд мөнгө хэрэгтэй. Тэгээд мөнгөний нэг эх үүсвэр бол энэ гадаад зээллэг, нэн хөнгөлөлттэй зээл, урт хугацаатай зээл ийм

зүйлүүд байгаа. Тийм учраас энийгээ авч ашиглах тал дээр зөвхөн энэ 2 хууль нэр заасан төслөөр хязгаарлахгүйгээр бүх ер нь төслүүд дээрээ нэг шинжилгээ хийж, энэ дээрээ нэг анхаарч ажилламаар байна аа.

Тэгэхээр би одоо Сангийн яам энэ Засгийн газраас асуух гээд байгаа нь яг Монгол Улс хэчнээн яг албан ёсны хэлэлцээр хийгээд нэн хөнгөлөлттэй авч ашиглах ийм хэдэн төгрөгийн зээл гадаадад ашиглаагүй зээл хүлээгдэж байна аа. Ер нь яг энийгээ бас дотор нь эрэмбэлж байгаа юу? Одоо маш их жишээлбэл Арабын сантай нэлээн өндөр дүнтэй хэлэлцээр хийсэн. Тэр мөнгөөр Улаанбаатар Лүн чиглэлийн 6 эгнээ зам тавина гэж ингэж ярьж байсан. Гэтэл сүүлд бас Дэлхийн банкны санхүүжилтээр хийх тухай ярьж байна.

Тэгэхээр ер нь яг энэ хэр хэмжээний гадаад зээллэгийн хэлэлцээр хийчихсэн байгаа вэ? Энэнээсээ одоо яг ингээд бүрэн дүүрэн ашиглаад, энэ том төслүүдээ цаг хугацаанд нь ашиглаад ашиглалтад оруулаад явах боломж байгаа гэж харж байна уу? Засгийн газар.

Ер нь заавал энэ 2 төслөөр хязгаарлахгүйгээр энэ бүх юмаа нэг нэгдсэн журмаар сайн яриад тодорхой мэдээлэл өгөөч ээ гэж ингэж хүсэж байна.

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 1991 оноос хойш Монгол Улс нийтдээ нэг 10.4 тэрбум ам.долларын зээл авсан буюу одоо 33.4 их наяд төгрөгийн төслийн зээлийн хэлэлцээрээ олсон. Өнөөдрийн байдлаар 6.1 тэрбум ам.доллар буюу 19.6 их наяд төгрөгийг нь ашигласан байна. 4.3 тэрбум ам.доллар буюу 13.8 их наяд төгрөгийг бид нар зээлийн хэлэлцээрийг ашиглаж чадаагүй байж байна. Тэгэхээр цаашдаа бид нар энэ одоо нийт зээлийн хэлэлцээр 74 гадаадын зээлээр хэрэгжиж байгаа төсөл байгаа. Энэ 2 төслийн маань энэ жилийн нийт хэрэглээ нь 1.8 их наядын шаардлагатай байгаа энэ төслүүдийг явуулахад.

Тэгэхээр одоо ашиглаж чадаагүй байгаа 13.8 их наядын маань 5.3 нь зөвхөн Эрдэнэбүрэн, Газрын тосны үйлдвэр маань байгаа юм. Бараг 40 хувь нь. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтаар бид нар энэ 2 төслийг төсвийн хязгаараас гаргаснаараа цаана нь бид нар төсвийн хязгаарт суусан 1 аравны гадаад зээлийн ашиглалтын 1.2 их наядын хүрээнд улсад үлдэж байгаа 72 төслөө санхүүжүүлээд явах тэр боломж бас байгаа юм. Ихэнх төслүүд маань 2029 он гэхэд ашиглалтад орохоор ингэж төсөвлөгдөж байгаа. Зүгээр энэ жил өргөн барьсан сая өргөн барьсан эдийн засгийн юу төсвийн хүрээний мэдэгдэлд бол ирэх жилүүдэд Зээлийн ашиглалтад бас тодорхой орон зай гарахаар тусгагдсан байгаа.

**С.Бямбацогт:** Хосбаяр гишүүн тодруулъя.

**Г.Хосбаяр:** Зам тээврийн салбарт ер нь яг одоо хэдэн төгрөгийн гадаад зээлийн ашиглаагүй үлдэгдэл байгаа вэ? Дэлхийн банк, АХБ мөн энэ гаднын бас хэлэлцээрүүд байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхтэйгээ зэрэг энэ өргөн уудам нутагтай манай улсын хувьд энэ зам замын бүтээн байгуулалтын ажил чухал байна л даа. Тэгэхээр энэ зам дээр ер нь ЗТЯ-н дээр яг ашиглаагүй үлдэгдэл гэх юм уу ямар хэмжээтэй байгаа вэ? Ер нь цаашдаа бас энэ авто замын салбарын хөрөнгө

оруулалтыг энэ нэн хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр хийгээд явах ийм бодлого барьж байгаа юу? Түүнээс биш одоо улсын төсөв бол даахгүй, улсын төсөвт суулгах боломжгүй болсон гэдэг нь тодорхой болсон. Миний авсан мэдээллээр ЗТЯ-н дээр бас маш олон зураг төсөл хийгдсэн байгаа боловч одоо ингээд санхүүжилтийн эх үүсвэр байхгүй гээд зогсожчихоод байж байгаа. Тэгэхээр энэ тал дээр Зам тээврийн сайд бас нэг хариулт хэлээч.

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариулах уу? Ажлын хэсэг хариулах ёстой болохоор Дэлгэрсайхан сайд хариулъя.

**Б.Дэлгэрсайхан:** Зам тээврийн салбарт ер нь одоогоор энэ Дарханы хучилтын нэмэлт 5 санжийн хучилтын 20 сая долларын үлдэгдэл байгаа. Энийг ингээд энэ жил хийгээд дуусгачихна. Ер нь Лүнгийн зам дээр бид бас 6 эгнээ зам дээр Кувейтийн сан буюу Дэлхийн банктэй ингээд ярьж байгаа. Тэгээд энэн дээр бас Лүнгийн энэ 101.7 км 6 эгнээ зам бол баруун тийшээ гарч байгаа 9 аймгийн нийт бараг сая гаран зорчигч явдаг ийм замыг бид нар хийхээс өөр арга байхгүй. Тэгээд энийг ойрын үед эхлүүлэхээр ингээд төлөвлөж байгаа. Тэгээд ОУБ-тай ярилцаж байгаа ийм байгаа. Мөн одоо зам тээврийн салбарт төр хувийн хэвшлийн түншлэлээр буюу өөрийн чинь хэлдгээр төсвийн хөрөнгөөр барьж чадахгүй...

**С.Бямбацогт:** Хариултаа гүйцээчихье. Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Төр хувийн хэвшлийн түншлэлээр энэ хүнд даацын буюу энэ том замуудыг эхлүүлэх ийм арга хэмжээ авч байгаа. Өнөөдөр одоо энэ ирэх бүтэн сайн өдөр анхны энэ Замын-Үүд, Говьсүмбэрийн хүнд даацын 100 тонны ийм тусгай зориулалтын авто замыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр 490 км зам ажлаа эхэлж байгаа. Ийм хэмжээнд л байгаа.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалангийн урилгаар Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал хөтөлбөрийн оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Өөрчлөлтийг манлайлж яваа эмэгтэйчүүддээ бас амжилт хүсье ээ. Та бүгдийн хүчин чармайлт санаачилга бидэнд бас үргэлж хэрэгтэй шүү. Тэгээд манай Жаргалан гишүүн өөрөө тэнд байж байна. Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч, манай Улсын Их Хурлын бас эмэгтэйчүүдийн залуучуудын бас идэвхтэй дуу хоолой болсон гишүүн хамт явж байна аа. Амжилт хүсье ээ.

Хосбаяр гишүүн дахиж тодруулъя.

**Г.Хосбаяр:** Сангийн яамнаас дахиад нэг юм асуучихъя. Энэ гадаад авч ашигласан зээлүүд түрүүчийн усны компакт төсөл ч гэдэг юм уу, цэвэрлэх байгууламж ч гэдэг юм уу ийм томоохон дүнтэй зээлийн хэлэлцээрүүд түрүүчийн төслүүд нь дуусаж байх шиг байна. Зарим нь дуусчихсан байгаа. Тэгэхээр энэ одоо ингээд дууссанаар шууд тэр нөгөө бид нарын яриад байгаа хязгаараас үнийн дүнгээрээ хасагдаад, дараагийн зээлийг авч ашиглах ийм боломж нөхцөл үүсдэг юм уу эсвэл одоо бүүр тэр мөнгө төгрөгийг нь төлж, тэр урт хугацаандаа бүрэн дууссаны дараа тийм орон зай нь гардаг юм уу?

Ер нь одоо цаашдаа дахиад л зөндөө л хэлэлцээр хөнгөлөлттэй зээлийн нөхцөл боломжууд гарч ирэх байх. Энийг ер нь авч ашиглах тал дээр хэр боломжтой юм бэ? Тэгэхгүй бол одоо ингээд үнэхээр хязгаар нь тулчихсан юм бол дахиж

хэлэлцээр хийгээд ч нэмэргүй юм биш үү? Ажил хийх боломжгүй юм биш үү? Тэгэхээр энэ дээр яг тэр ажил нь дууссан л бол тэр үнийн юу гэдэг юм Усны компакт төсөл гэхэд 300 сая доллар гэвэл ажил нь дууслаа бол тэр 300 саяын орон зай...

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариульъя.

**З.Мэндсайхан:** Хосбаяр гишүүний асуултад хариульъя.

Түрүүн асуугаад байсан зам тээврийн салбарт нийтдээ 7 төсөл хэрэгжиж байгаа. 1.9 их наяд төгрөгийн зээл байгаа. Амлалт бүхий 7 төсөл байгаагаас одоо зээлийн үлдэгдэл нь 1 их наяд байгаа шүү. Ер нь зээлүүд төслүүд хэрэгжээд дуусахад ашигласан дүнгээрээ өрийн тооцоололд ороод явна. Мянганы сорилын сангийн тэр сая цэвэр усны төсөл бол зээлийн юу тусламжийн төсөл байгаа. Тэгээд өрийн тухай Өрийн удирдлагын тухай хуулиар бол бид нар энэ зээл авах тааз чинь ДНБ-ний 60 хувьд хүртэл байгаа. Одоо манай зээл бол 38 хувьд байгаа. Тэгэхээр бид нарт бол өрийн тааз хангалттай орон зай байгаа. Гол асуудал бол бид нар авсан зээлээ ашиглах нь тэр хязгаар нь төсвийн хуулиараа хязгаарлагдаад байгаа юм. Тийм учраас энэ төслүүдийг оруулж ирсэн.

**С.Бямбацогт:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

**Х.Тэмүүжин:** Түрүүн энэ хуулийн төсөл Улсын Их Хурал дээрээс буцсан. Тэгээд Улсын Их Хурал дээрээс буцсаны дараагаар манай Засгийн газар улс оронд хэрэгтэй хамгийн чухал 2, 3 төсөл Улсын Их Хурал дээр ингээд уналаа гэдэг шүүмжийг Улсын Их Хурал руу хаяглаж бас нэлээн ширүүхэн хэлээд байх шиг байна лээ. Нэг зүйлийг энд хэлэхгүй бол үнэхээр болохгүй байгаад байгаа юм. Ер нь Засгийн газар өөрөө өөрийнхөө ажлыг өөрөө хийж сурах хэрэгтэй. Төсвийн хүрээгээс хүрээнээс гадуур төсвийн сахилга батыг алдагдуулахад болзошгүй тэгэхдээ авсан зээлийнхээ ашиглалтыг нэмэгдүүлье гэж байгаа энэ бодлогоо өөрсдөө өөрийнхөө нэрээр өргөн бариад Улсын Их Хуралд оруулж ирэх ёстой байхгүй юу. Тэгсэн харамсалтай нь Засгийн газар заль хэрэглэсэн. Энэ зээл нэг удаа биш 2, 3 удаа харагдаж байгаа.

Улсын Их Хурлын гишүүдээр өргөн бариулдаг, ард нь Засгийн газар нуугдчихдаг. Тэгээд алдаа эндэгдэл юм уу эс үгүй бол муу нэр болбол Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө тэрийгээ үүрнэ биз гэж боддог юм уу яадаг юм. Энэ буруу байгаа байдлаас чинь болоод энэ төслүүд буцаж явсан шүү дээ. Тэгэхлээр Засгийн газар өөрөө өөрийнхөө нэрээр ийм асуудлаа өргөн бариад бодлого нь юу байгаа юм тайлбараа хийгээд Улсын Их Хурал дээр асуудлаа шийдүүлээд явж сурах хэрэгтэй цаашдаа. Тэгэхгүй бол Улсын Их Хурлын гишүүдээр могой бариулж байгаа юм шиг нэг ийм ажил хийлгээд тэгээд яг энэний үндсэн дээрээ бол гүйцэтгэх эрх мэдэлд худалдагдсан Улсын Их Хурлын гишүүд байгаа юм биш үү гэдэг эргэлзээг олон нийтэд төрүүлж байгаа. Маш их том хэмжээний мөнгөн дүнтэй. Төсвөөс төсвийн гадуур зарчим эвдэж явах гэж байгаа энэ асуудлыг өргөн бариад хэлэлцүүлж байгаа Улсын Их Хурлын гишүүдийг ард иргэд ингэж хардах нь зүйн хэрэг шүү дээ.

Энд чинь улс төрийн авлига яваад байгаа юм биш үү. Энэ төсвийн ар дээр энэ Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын өмнүүр орж ажил хийж төсвийг ингэж бужигнуулж байгаа чинь ардаа ямар тохироо хийсэн юм, ямар хэмжээний мөнгө мөнгөн сонирхол явж байгаа юм. Ийм байдлаар Улсын Их Хурал Засгийн газарт хяналт тавих ёстой чиг үүргээ эсрэгээр нь Засгийн газрын өмнөөс Улсын Их Хурал

руу асуудлыг нь барьж ордог гал хамгаалагч хийж байгаа чинь парламентын нэр хүндийг бас унагахад хүрч байгаа. Тэгэхлээр энэ зарчмын бөгөөд суурь шинжтэй энэ алдаагаа засаад өнөөдөр Улсын Их Хурал өөрөө оруулж ирж байгаа нь одоо таатай байна.

Ер нь бол Улсын Их Хурал дахиад дотроо энийгээ бас нэлээн сайн ярих ёстой. Парламент гэдэг бол төлөөлөл, хууль тогтоох Засгийн газарт хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа. Гэтэл Засгийн газарт хяналт тавих ёстой сайдууд нь Засгийн газрын нэрийн өмнөөс төсвийг 2 болгох, төсвийн сахилга батыг алдагдуулах, дараа нь хяналт тавихад буцаад ашиг сонирхлын зөрчил үүсэх ийм хэмжээний ажил хийдгээ бас Улсын Их Хурлын гишүүд болих ёстой байх. Хамгийн гол нь Засгийн газар Улсын Их Хурлын гишүүдээр өөрсдийнхөө галтай сэдвийг бариулж, гал баригч хийлгэдгээ бас болих хэрэгтэй байх.

Сүүлдээ Засгийн газар нь нэр цэвэр, Улсын Их Хурал нь авлига, уул уурхай авлигын үүр уурхай болчихсон тийм болж харагдаж байна шүү дээ. Сүүлдээ Засгийн газар нь хэвлэлээр пиар хийгээд, мөнгө тараагаад Улсын Их Хурлыг ямар муу муухай болгох тухай өөрсдөө цаана нь ард нь ямар ариун цэвэр болох тухай тийм пиар хийгээд сууж байна шүү дээ. Тэгээд ийм байдлыг бол дахиад гаргамааргүй байна аа. Улсын Их Хурлын дарга ч гэсэн энэ дээр анхаармаар байна.

**С.Бямбацогт:** Үг хэлчихлээ тийм ээ. Тэгээд бас цаашдаа анхаарах ёстой асуудлууд хэлж байна аа. Бид хэд бас анхааралдаа авах ёстой шүү энийг. Хаана асуудал гарч байна, хаана бас алдаа дутагдал байна тэр болгоноо тухай бүрд нь яриад сайжруулаад явж байх ёстой. Тантай санал нэг байна аа. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

**Ө.Шижир:** Өглөөний мэнд. Тэмүүжин гишүүнтэй зарим юм давхацсан учраас шууд асуулт руугаа оръё. Одоо энэ өргөн барьж байгаа юун дээр газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС 2 том төсөл байгаа. За үүнийг дагаад ажиллах хүчний асуулт заавал яригдана. Гэтэл бид нар яг энэ газрын тос болон УЦС дээр шаардлагатай монгол инженерүүдийг бэлтгэж чадаж байгаа юу гэдэг нэг асуулт байна. Чадаж байгаа бол хэдэн оюутан хэдэн мэргэжилтнийг хаана яаж ямар хэмжээний зардлаар бэлдэж байгаа вэ гэдэг дээр хариулаад өгөөч.

Сүүлийн жилүүдийг ингээд харах юм бол Монгол Улсаас гадаадаас ажиллах хүчний тоо сүүлийн жилд өмнөх жилээсээ дандаа 30 хувийн өсөлттэй байгаад байгаа юм. Жишээ нь 2025 онд дунджаар 16027 иргэн дунджаар шүү. Монгол Улсад гадаадаас хөдөлмөрийн гэрээгээр ирж ажил эрхэлсэн бол яг өнөөдрийн байдлаар 11814 болчихоод байгаа юм. 2025 оны 3 сарын 1-ний байдлаар оргил үе нь буюу 23821 хүн гаднаас ирж ажилласан байна. Тэгтэл Монгол Улсын ажилгүйдлийн түвшин өөрөө 5.6 хувь, нийтдээ ажилгүй 200 мянга орчим иргэн байгаа. Тэгэхээр ажилгүй иргэдийнхээ ажлын байрыг хэрхэн хамгаалах вэ? Үүн дээр ямар бодлоготой байгаа вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Энэ 2 төсөл дээр хоёулан дээр нь ажиллах хүчний харьцаа гадаад монгол иргэдийн харьцаа хэд байгаа юм, инженер, техникийн ажилчдын харилцаа хэд байгаа юм, удирдлагын багийн түвшний харилцаа хэд байгаа юм, цалингийн ялгаа хэд байгаа юм гэдгийг бүүр яг нарийн деталь тоо мэдмээр байна. Яагаад ингээд асуугаад байна вэ гэхээр энэ 2 чинь магадгүй тодорхой хугацааны дараа ашиглалтад орно. Ашиглалтад орохоор үргэлжлүүлээд аваад явах Монгол

мэргэжилтнүүд бэлтгэгдэж байгаа юу, ажиллах хүчгүй болоод зогсчих вий гэдэг нэг ийм бас айдас эрмэлзэл байна. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Нөгөө талдаа дахиад 3 дахь асуулт нь Сангийн сайдаас байна. Энэ 2 төслийн анхны төсөвт өртөг өнөөдрийн байдлаар хэдэн хувиар өсөн нэмэгдсэн байгаа юм анхны ТЭЗҮ-нээсээ. Анхны ТЭЗҮ-гээс нь шүү. Ингээд анхны төсөвт өртөг болон ажиллах хүч, тэр ажиллах хүчний талаар Хүн ам, нийгмийн хамгааллын яам хариулах уу, хаанах хариулах юм бол. Энэ дээр хамгийн гол зүйл бол бид нар ажиллах хүчин шүү дээ. Эргээд үлдэнэ, энэ үйлдвэр бид нарт үлдэнэ. Хэзээ нэгэн цагт татвар төлөгчдийн мөнгөөр энэ зээлийг бид нар төлж л дуусгана. Энэ чинь ирээдүйд одоо ирээдүйд олох орлогоосоо л бид нар урьдчилж зээл авч байгаа л хэлбэр шүү дээ. Тэгэхээр эргээд үйлдвэрүүд ашиглалтад ороход хэчнээн хүн ажлын байраар хангагдаад, хэчнээн инженер яг одоогийн байдлаар бэлтгэгдэж байгаа юм.

Тэгээд энэ 2 төсөл хоёулаа яг хэдэн оны хэдэнд одоогоор ашиглалтад орохоор төлөвлөгдөж байгаа юм. Хойшилсон шалтгаанууд нь юу юм. Төсөвт өртөгт нэмсэн шалтгаанууд нь юу юм, ажиллах хүчээ яаж бэлдэж байгаа юм. Ирээдүйд үлдэх өрийг бид нар ирээдүйд орлогоосоо төлж л таарна. Тэгэхээр тэнд байгаа ажилчдаа яаж бэлдэж байгаа юм гэдэг ийм нэг 3 асуудал дээр бүүр яг тодорхой тоонуудтай жишээ хариулт авмаар байна. Яагаад гэхээр юу гэж хэлээд байна вэ гэхээр 2025 оны 3 сарын 1-ний байдлаар 2830-д 21 хүн гаднаас ажиллах хүч гэрээгээр орж ирж байсан юм байна. Тэгэхэд 2026 оны буюу энэ оны 1 дүгээр сарын төгсгөлөөр 11814 аль хэдийн орж ирээд гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүсийн хэд нь энэ 2 төсөл дээр ажиллаад байгаа юм бэ гэдэг бас тодорхой хариулт яг тоотой авмаар байна.

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариулъя.

**3.Мэндсайхан:** Шижир гишүүний асуултад хариулъя.

Эрдэнэбүрэнгийн төслийн хувьд төсөвт өртөг бол огт нэмэгдээгүй. Хийгдсэн ТЭЗҮ-гийнхээ дагуу санхүүжилт нь төсөл маань хэрэгжээд явж байгаа. Газрын тосны хувьд анх Энэтхэгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 1 тэрбум ам.долларыг олгосон. Энэ хүрээндээ бол газрын тосны үйлдвэрийн маань анх олгохдоо бол газрын тосонд гэж олгогдоогүй, шийдэгдээгүй байсан учраас дараа нь газрын тосны үйлдвэрийг барья гэж шийдвэр гарсны дагуу ТЭЗҮ боловсруулагдсан. Ингээд ТЭЗҮ боловсруулагдсанаараа 1.2 тэрбум доллар болоод болж нэмэгдсэн байгаа. Сүүлд 2024 онд 467 сая доллар нэмэгдээд ингээд нийтдээ 1.7 тэрбум болсон. Энэ нь сүүлд нэмэгдсэн нь бол Улсын Их Хурлаар мөн хэлэлцэгдэж дэмжигдсэн байгаа. Энэ нь өөрөө яагаад нэмэгдэх болсон гэхээр Пи Си 4 буюу нөгөө лицензийн барилга дээр ТЭЗҮ нь эцэслэн батлагдсанаараа тэр өөрчлөлт дээр нэмэгдсэн байгаа. Тухайн үедээ Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд дэмжигдээд явсан ингээд нийтдээ 1.7 тэрбум доллар болсон байгаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг хариулъя нэмж Дамдинням сайд. Дараагийн асуултад бас юу бэлдэж байгаарай.

**Г.Дамдинням:** Шижир гишүүнд газрын тосны үйлдвэртэй холбоотой асуудлаар хариулт өгье. 1 дүгээрт бол яагаад энэ ашиглалтын асуудал яригдаад байгаа вэ гэхээр бид нар одоогийн байдлаар зээлээ 25.6 хувьтай л ашиглаж байгаа. Гүйцэтгэл ер нь бараг 50 хувь руу хүрчихсэн явж байгаа. Төсөл ингээд удаад байгаа

юм шиг яригдаад байгаа боловч яг бодит байдал дээр хөөрхий 2021 онд эхлээд анхны санхүүжилтээ жил 3 сарын дараа авсан байдаг байхгүй юу энэ хүмүүс. Яг бас энэ төсөл хэрэгжүүлэгчийн дуу юмыг сонсвол бас их түвэгтэй хөөрхий. Өөрөөр хэлбэл бас манай хүнд суртал, дээрээс нь ингээд нэг ийм цоо шинэ салбартай зууралдаж байгаа учраас мэдэхгүй юм ихтэй. Зураг төсөл нь байна одоо. Зураг төслийг нь жишээ нь бүтэн цогцолбороор нь хүлээж авна аа гээд Барилгын хөгжлийн төв ингээд гацаачихсан. Гэтэл уг нь бол тэрний чинь шугам хоолой, суурь бүтэц гээд тус тусад нь аваад яваад байдаг дэлхийн жишигтэй. Энэ асуудлуудыг нь шийдээд явж байгаа. 550 шууд ажлын байр бий болно. ШУТИС дээр 51 хүний тэтгэлэгтэй байнгын анги одоо.

**С.Бямбацогт:** Хариултаа дуусгачихъя. Дамдинням сайд.

**Г.Дамдинням:** ШУТИС дээр 51 хүнийг тэтгэлэгтэйгээр сургаж байгаа. Өчигдөр гэхэд гүйцэтгэгч компани болон менежментийг хэрэгжүүлж байгаа төслийг хэрэгжүүлж байгаа удирдах компанитай уулзаж 4 асуудлыг ярьсан. 1 дүгээр асуудал энэ асуудлууд дотор ямар асуудлууд яригдсан бэ гэхээр ийм асуудлууд яригдаж байгаа. Төсөл ингээд удахгүй ашиглалтад орох болж байгаа учраас энэ жилийн төгсгөлөөс эхлээд энэ төслийг цааш нь удирдаж авч явах нэг 30-50 хүнийг байнгын ажиллуулаад энэ төслийнх нь үйл ажиллагаанд бэлдэж явъя гэдэг ийм зарчмын асуудлуудаа ярьж байна.

Хоёрдугаарт энэ төсөл маань ингээд хэрэгжээд түүхий эд гараад ирэх дээр зэрэг энийг хэрхэн тээвэрлэх вэ. 200-300 вагон цистерний асуудал яригдана. Тэгээд Монголын ААН-үүддээ энийг яаж зохицуулах вэ гээд төслөө хэрэгжээд эхлэхэд бэлтгэл ажлыг нь хангах тухай асуудал.

Гуравдугаарт төсөл хэрэгжээд дуусангуут эргэлтийн хөрөнгийн асуудал гээд асуудлуудыг бэлдэх чиглэлийн ажлууд ингээд эхлээд явж байгаа.

**С.Бямбацогт:** Сангийн яам, 3 дугаар микрофон, ажлын хэсэг хариулъя. Шижир гишүүний асуултад ажиллах хүчтэй холбоотой. Энэ 2 төсөл дээр гадаадаас хэдэн ажиллах хүч орж ирж ажиллаж байгаа вэ. Цаашдаа энэ гадаадад ажиллах хүчний талаар бас ямархуу бодлого байгаа вэ гэдэг асуудал яригдаж байгаа.

**Ж.Дэлгэржаргал:** Шижир гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр газрын тосны боловсруулах үйлдвэрүүд дээр одоо яг 2500 ажилчин ажиллаж байгаа. Ер нь энэ жил яг энэ санхүүжилт зээлийн ашиглалт нэмэгдэхээр нийтдээ 4500 хүн үйлдвэр дээр, бүтээн байгуулалтан дээр ажиллана гэж тооцоолол явж байгаа. Үйлдвэр ашиглалтад орсноор хамгийн багадаа 700 яг ажлын байр бий болно. Эрдэнэбүрэнгийн УЦС-ын хувьд бол үйлдвэр станц маань ашиглалтад ороод 870 хүн яг ажлын байр бий болно гэсэн тооцоолол байгаа.

**С.Бямбацогт:** Шижир гишүүн тодруулъя.

**Ө.Шижир:** Тэгээд энэ бүтээн байгуулалт чинь ингээд тодорхой хугацааны дараа дуусна шүү дээ. Тэгээд ашиглалтад ороод эхэлнэ. Энд саяын ажиллаж байгаа 2500 гаднын газрын тос дээр 2500 ажиллаж байгаа тэр гаднын ажиллах хүчин буцна. Тэгэхээр тэрэн дээр зөрөөд ажиллах манай инженер техникийн

ажилтан бэлэн байгаа юу? Эрдэнэбүрэн дээр чинь бэлэн байгаа юу. Тэр хүний нөөцийн бодлого чинь байгаа юу гэдгийг би асуугаад байгаа юм. Гол асуулт нь энэ юм. Энэ 2 бүтээн байгуулалт чинь дуусна аа. Бид нар хүлээж авна аа, ашиглана аа. Тэгээд бүтээгдэхүүнүүд гараад эхэлнэ ээ, худалдаанд гараад эхэлнэ ээ. Тэгэхээр бид нар энэ дээр хүний нөөцийн бодлого чинь байгаа юм уу гээд байна шүү дээ. Бид нар ажиллах хүчний хомсдолд орчихсон юм шиг ийм тоонууд харагдаад байна аа гэдэг нь гаднаас орж ирж байгаа ажиллах хүч чинь сүүлийн жилүүдэд өмнөх жилээсээ дандаа 30 хувийн өсөлттэй байгаад байна аа.

Яг өнөөдрийн эхний үйлдэл 1 дүгээр сарын байдал гэхэд 11 мянга ороод гаднын ажиллах хүч ороод ирчихсэн байна аа. 2025 оны 3 сарын 1 гэхэд 23821 хүн ажиллаж байсан байна гаднаас ажиллах хүч. Тэгэхээр энэ 23821 хүн энэ төслүүд дээр ажиллаад байгаа юм уу, өөр төслүүд дээр ажиллаад байгаа юм уу гэж асуугаад байна аа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг 3 дугаар микрофон.

**Ч.Хишигдалай:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Үйлдвэр ашиглалтад орохоор 550 инженер техникийн ажилчид хэрэг болно. Үүнийг бол бид нар ШУТИС болон БНЭУ-уудад үе шаттайгаар бэлдэж байна. Өнөөдөр ШУТИС дээр 51 оюутан тэтгэлэгтэй сурах суралцаж байна. Энэ ЕРС 2, 3, 4 дүгээр багц дээр ялсан гүйцэтгэгч компаниуд бол тухайн тоног төхөөрөмжийг ашиглалтад орохоос 6 сарын өмнө Инженерийн суурь мэдлэгтэй боловсон хүчнийг дадлагажуулж туршлагажуулж ажиллах үүрэг хүлээсэн байгаа гэрээгээрээ. Үйлдвэр ашиглалтад оронгуут Энэтхэгээс мэргэжилтнүүд хүрч ирээд дагалдан сургах маягаар эхний нэг жилийн хугацаанд дадлагажуулаад цаашаа үйлдвэрээ аваад явах мэргэжилтнүүдийг бэлтгэж гаргах ёстой. Яг өнөөдөр бол үйлдвэр дээр 100 орчим хүн бас яг үйлдвэрийнхээ бүтээн байгуулалтын ажилд оролцоод эхнээс нь зураг төсөлтэйгөө ажиллаад бүтээн байгуулалт дээр газар дээр нь ажиллаад явж байгаа.

**С.Бямбацогт:** Нэмээд тэр энэ гаднаас орж ирж байгаа гадаад ажилчид яг энэ төслөөс гадна хаана хаана ажиллаад байгаа вэ гэсэн мэдээлэл хүсэж байна. Ажлын хэсэг Сангийн яам.

**Ж.Дэлгэржаргал:** Шижир гишүүний асуултад нь нэмэлт тайлбар өгье. Сангийн яам Дэлгэржаргал.

Тэгэхээр гадаад зээлийн төслүүд хэлэлцээр анх батлахдаа угаасаа квотоо тогтоодог. Өөрөөр хэлбэл тухайн төсөл дээр нийт хэдэн ажилтан байх вэ, гаднаас яг хэд орж ирэх вэ, дотоодоос ямар ажилтан авах вэ гээд. Тэр хүрээндээ нийт энэ хэрэгжиж байгаа 74 төсөл бол бүгдээрээ яг ажиллах хүчний асуудал явж байгаа. Тэгээд энэ хэлэлцээрийнхээ дагуу гаднаас ирэх ажилчдынхаа ажлын байрны төлбөрөөс нь чөлөөлөөд явдаг Засгийн газрын тогтоолоор. Хэлэлцээр болгон дээр ялгаатай байгаа. 70:30, 60:40 гээд ялгаатай байдаг тухайн төслөөсөө. Тэгээд дийлэнх төслүүд маань өөрөө энэ 2 төслөөс гадна хамгийн 5 том салбарт явж байгаа. Улаанбаатар хотын дэд бүтэц орон сууцжуулалттай холбоотой, эрчим хүчний салбар, авто замын салбар дээр бол дийлэнх төслүүд явж байгаа. Тэгэхээр яг энэ ихэнх харьцаа бол 60:40, 70:30 байгаа.

**С.Бямбацогт:** Шижир гишүүн нэмж асууя.

**Ө.Шижир:** Тэгээд бид нар нөгөө нэг ажиллах хүчээ бэлдэхгүй бол юм аваад үлддэг, тэгээд ажиллаж чадахгүй, ажиллуулж чадахгүй, тэгээд хасах зардал руугаа орох вий л гээд байгаа шүү дээ. Энэ чинь нөгөө нэг бид нар төлөхгүй татвар төлөгчдийн л мөнгө төлнө.

2 дугаарт жишээ нь Аж үйлдвэрийн яамнаас болохоор шууд ажлын байрыг 550 гэж ярьсан. Сангийн яамнаас 700 гэж тоо ярьсан. Энэ 150-ийн зөрүү нь хаанаа гарч ирсэн тоо юм. Нэг нь 550 гэж ярьсан, нэг нь 700 гэж ярьсан шүү. Тэгээд нэг төслийг 2 өөрөөр ярьж байна гэсэн үг шүү дээ. Нэг төслийнх нь ажиллах хүчний тоог. Тэгэхээр энэ тооныхоо ялгааг тайлбарлаад өгөөч?

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг 3 дугаар микрофон индрийн.

**Ч.Хишигдалай:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 550 бол газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын тоо. Нэмэгдэж байгаа 150 бол дамжуулах хоолой дээр ажиллах ажилчдын тоо ингээд энэ төсөл нийтдээ 700 хүн ажлын байраар хангагдана. Шууд ажлын байраар.

**С.Бямбацогт:** Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

**Ц.Баатархүү:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Сангийн сайдаас асууя. Хот байгуулалтын сайд байхгүй байна. Энэ гадаадын зээлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг эрэмбэлээд явцын дүгнэлт Сангийн яам хийж байгаа юм уу. 2015 онд Улсын Их Хурлаар Азийн хөгжлийн банкны шугамаар нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих тусгай замын автобус төслийн зээлийн хэлэлцээрийг баталсан. Төслийн нэгж байгуулагдаж олон хүн цалин авдаг аа. 2015 он шүү дээ. Одоо хүртэл энэ үйл ажиллагаа төсөл нь хэрэгждэггүй ээ. Жил болгон ингээд зээлийн хүүд нь хүү төлөөд явж байдаг. Татвар төлөгчдийн мөнгийг зээлийн хүүнд төлөөд байдаг. BRD буюу тусгай замын автобус төсөл шиг хэдэн ийм төсөл зээлийн хэлэлцээр хийчхээд хэрэгжихгүй, төслийн нэгж нь цалин аваад яваад байгаа юм бэ гэдгийг Сангийн яам нэг тодорхой хариулж өгөөч ээ

Хоёрдугаарт нь Сангийн яамныхан энэ жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг зээлийн хүүд төлөх юм байна аа. Зээлийн хүү нь 4.5 юм уу яг тодорхой энэ дээр тоо хэлээч ээ. Засгийн газар бол төсвийн тогтвортой байдлын өрийн хязгаарыг давуулж тойруулж бултуулсан хууль оруулж ирж байна аа. Хууль зүйн логикийн хувьд дахиад ийм хууль шинээр төрж гарах, зээл авах хязгааргүй зээл авах магадлал бий болчихлоо. Одоо 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл бидний хэлэлцэж байгаа төсөвтэй чинь энэ хууль зөрчилдөх юм биш үү? Юу гэж тооцсон юм бэ?

3.Зээлийг валютаар авна аа. Зээлийн хүүг валютаар төлнө өө. Гадаад худалдаа болон валютын ханшийн эрсдэлээ юу гэж үзэж байгаа юм бэ?

4.Зээл авбал хөгждөг гэдэг бодлоосоо татгалзах болоогүй юм уу? Энэ холимог санхүүжилтийн загвараар явж болох уу? Тодорхой хэсэг дээр нь Монголын хувийн хэвшил орох, тодорхой хэсэг дээр нь энэ Үндэсний баялгийн сангийнхаа хөгжлийн санг оруулах, дотоодын бонд гаргах. Ингээд дотоодын ААН-үүддээ ижил тэгш боломж олгоод энэ мега төслөө явуулж болдоггүй юм уу. Заавал яагаад ингээд өндөр хүүтэй зээлийг Төсвийн тогтвортой байдлын хуулийг тойруулан барин ингэж оруулж ирэх ёстой юм бэ?

5.Энэ явцын аудит гэж байна уу? Техник эдийн засгийн тэр үндэслэл чинь буруу хийгдсэн юм уу? Яагаад ингээд төсөвт өртөг нь нэмэгдээд байгаа юм? Яг хэдэн хувиар нэмэгдээд байгаа юм бэ гэж асуухаар та хэд тодорхой хувь хэлэхгүй байна аа?

Ер нь хэзээ аудит орох юм бэ? Энэ 2 төслийг Улсын Их Хурлын гишүүд дэмжиж байгаа. Төслийг явуулж байгаа арга барил, төслийг удирдаж байгаа менежментийн багт бол бид нар илүү их итгэхийг хүсэж байна аа. Олон улсын аудит оруулах шаардлагатай гэж би хувьдаа бодож байна. Энэ дээр Сангийн яам тодорхой хариулж өгөөч ээ.

**С.Бямбацогт:** Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

**3.Мэндсайхан:** Баатархүү гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тогтвортой байдлын хууль тойруулж байгаа асуудал огт байхгүй 1 дүгээрт.

2 дугаарт төсөвт өртөг өссөн асуудал бол газрын тосны үйлдвэр дээр өссөн. Анх 1 тэрбум долларын хөнгөлөлттэй зээлийг Энэтхэгийн Засгийн газар олгохдоо газрын тосны үйлдвэрт тэгж зориулж олгоогүй. Монгол Улсад 1 тэрбум долларын хөнгөлөлттэй зээл олгоё оо гэдэг шийдвэрийг гаргасан. Энэ хүрээндээ бид хэлэлцээд газрын тос барих нь зөв зүйтэй юмаа гэдэг дээр баригдсан анхны урьдчилсан ТЭЗҮ 1.2 тэрбум доллар байсан. ТЭЗҮ эцэслэгдэн батлагдсанаараа 467 сая доллароор нэмэгдсэн. 2024 онд та бид хэлэлцээд энэ зээлийн ТЭЗҮ нь үндэслэлтэй байна аа гээд төсвийг нь баталж өгсөн байгаа 2 дугаарт.

Зээл авахаараа хөгжинө гэдэг ойлголтоосоо сал аа гээд. Ер нь зээл авах нь Өрийн удирдлагын тухай хуулиараа ч гэсэн бид нарт орон зайн хуулиа зөрчсөн асуудал байхгүй. Нийт ашиглалт маань орон зай бол 60 байгаа. Бид нар нэг 38.9 хувийг нь ашиглаад явж байна. Цаана нь бид нарт 20.1 хувийн 21 хувийн зээлийн орон зай байна. Тэгэхээр өрийн таазанд нөлөөлсөн Өрийн удирдлагын тухай хууль зөрчсөн асуудал байхгүй.

Хоёрдугаарт зээлийг бид нар энэ хөнгөлөлттэй зээлүүдийг Монгол Улс эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий эрэмбээр нь эрэмбэлж авч байгаа зээлүүд ээ. Томоохон төслүүдээ хэрэгжүүлж байгаа. Тэгэхээр зээлийг өр гэж харахаасаа илүүтэй та хөрөнгө оруулалт гэж харах ёстой. Бид нар боломж том төслүүдээ явуулах энэ газрын тосны үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулснаараа нийгэм, эдийн засгийн өгөөж нь Монгол Улсад хэрэгтэй. Газрын тосны дотоодынхоо нийт бүтээгдэхүүний 55 хувийг дотоодоосоо хангана. Баруун бүсийн эрчим хүч гэж ОХУ-аас 100 хувь хараат бус байна. Аймгууд байж байгаа. Энэ бие даасан эрчим хүчний бие даасан байдал чинь хангагдана аа. Тэгэхээр өр гэж харахаасаа илүүтэй бид нар энийг цаг хугацаанд нь хөрөнгө оруулалт болгож авч ашиглахын тулд энэ цаг хугацаанд нь бид нар ашиглаж чадах ёстой. Бид нар ашиглаж чадахгүй учраас ийм асуудалд орж, Төсвийн тухай хуулиараа 1.2 их наядын гадаад зээл ашиглах хязгаарыг та бид нар батлаад өгчихсөн. Тэрэнд чинь энэ жилийнх нь зөвхөн энэ 2 төслийн маань хэрэглээ нь 1.8 их наяд байгаа. Энэ 2 гарснаараа Төсвийн тогтвортой байдлын хуулийг зөрчөөд тойрч байгаа асуудал байхгүй. Төсвөөс гараад 2 төсөвтэй болоод явж байгаа асуудал огт байхгүй ээ.

Гадаад зээл дээр бүртгэлтэй явж байгаа зарлага нь бид нар дээр бүртгэгдээд явна гүйцэтгэлээрээ.

Ер нь энд гадаад зээлийн ашиглалттай холбоотой бид нар эрэмбэлж байгаа. Бүх аймаг яамдууд дээр байсан төслийн нэгжүүдийг нэгтгээд нэгдсэн төслүүдийг байгуулсан. Энэ бол бид нар үр ашигтай байдлыг нь нэмэгдүүлж байгаа. 327 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан. Энэ 2 төсөл маань зээлийн хязгаараас гарснаар төсвийн хязгаараас гарснаараа хөрөнгө баталгаажуулсны төлбөр буюу ашиглаж чадахгүй байгаа зээлийнхээ үлдэгдэл төлдөг төлбөр нийтдээ 104 тэрбум төгрөгийн 101.4 тэрбум төгрөгийн эрсдэл төлөлтөөс бид нар гарч байна гэсэн үг энэ. Хэрвээ энийг бид нар гаргаж чадахгүй бол хөрөнгө баталгаажуулсныхаа төлбөрт энэ хэмжээний мөнгийг төлөөд явна аа л гэсэн.

**С.Бямбацогт:** Баатархүү гишүүн тодруулж асууя.

**Ц.Баатархүү:** Сангийн сайд бас шинээр ажлаа авсан учраас ажилтайгаа танилцаж байгаа байх аа гэж бодож байна. Та бас жоохон тоотой тодорхой хувьтай хариулбал их сайн байна. Улс төрийн мэдэгдлээр хэдүүлээ энэ танхимд ярилцмааргүй байна. Энэ бол маш чухал 2 төсөл. Энэ 2 төслийн чухлыг бид мэдэж байгаа. Яагаад энэ холимог санхүүжилтийн хэлбэрийг бид нар сонгож болоогүй юм бэ гэж би асуугаад байгаа юм. Дотоодын бонд гаргаж болно, энэ үндэсний баялгийн санд байдаг хөгжлийн сангаа томоохон мега төсөл дээрээ эргэлтэд оруулж болно, төр хувийн хэвшлийн түншлэлийг ашиглаж болно. Ингээд олон оролцогчтой бол хяналттай болно оо. Ингээд олон оролцогчтой болох юм бол илүү хэмнэлттэй болно, ил тод болно. 240 тэрбум төгрөгийн хүүгээ валютаар төлөх юм уу, яаж төлөх юм. Валютын ханшны эрсдэлд ямар нөлөө үзүүлэх юм бэ. Ингээд дахиад зээл авъя. ТЭЗҮ-гээ тод...

**С.Бямбацогт:** Мэндсайхан сайд хариулъя.

**З.Мэндсайхан:** Баатархүү гишүүн ээ. Би нэг ажлаа мэдэхгүй байгаа асуудал огт биш ээ. Би танд тоогоор нь хариулж байгаа. Газрын тосны үйлдвэр 467 сая доллароор нэмэгдсэн. Энэ чинь 38 хувь, өмнө нь 1.2 их наяд байсан бол тийм ээ. 467 сая буюу 38. Ихэнх зээлүүд маань холимог хэлбэрээр явж байгаа таны асуугаад байгаа. Эх үүсвэр нь Монголын талын санхүүжилтийн тодорхой хувийг нь бид нар олон улсын зээлийн хэлэлцээрийнхээ хүрээнд төлөөд явж байгаа. Монголын Засгийн газар хэрэгжсэн бүх гадаад зээлийн төсөл дээр хариуцах нь 5 хувиа 5-8 хувийг төлдөг хариуцдаг энэ төслөө бид нар холимог хэлбэрээр хариу хамтраад хэрэгжүүлээд явж байгаа.

Тэр зээлийн эрсдэл дээр бид нар таны яриад байгаа хүүгийн эрсдэл болон төсөвт өртөг нэмэгдүүлэхгүйн тулд энэ зээлүүдийг хугацаанд нь ашиглалтад оруулна. Тэгж байж нийгэм эдийн засгийн өгөөж нь ирнэ. Тиймгүй хугацаанд нь ашиглаж чадахгүй бол яг таны яриад байгаа эрсдэл үүснэ ээ. Тэрэнтэй санал нэг байна.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Тодруулах уу, гайгүй юу? Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү, Нацагдоржийн Батсүмбэрэл нарын урилгаар ЧД-ийн ӨЭМТ-ийн эмч сувилагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Хүний амь насыг гартаа атгаж үхэлтэй нүүр тулдаг эмч, эмнэлгийн ажилтнууд та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн

нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Манай Баатархүү гишүүн маань байна. Батсүмбэрэл гишүүн маань дотроо явж байгаа байх. 2 гишүүн ажлаа сайн хийж байгаа шүү гэж манай Даваагийн Цогтбаатар гишүүн дамжуулж байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр яг улс орны хөгжилд хэрэгтэй 2 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх асуудал орж ирж байгаа учраас яалт ч үгүй дэмжиж таараад байгаа юм. Тэгэхдээ би бол энэ Эрдэнэбүрэний УЦС-ын төсөвт өртөг бол нэмэгдээгүй гэж ойлгож байгаа. Зүгээр санхүүжүүлэх асуудлыг л шийдвэрлэж байгаа. Гэвч нөгөө газрын тосны үйлдвэрийг барихтайгаа холбоотой зардлууд бол байнга нэмэгддэг. Тэрэн дээр нэг одоо Алтанцэцэг гэдэг эмэгтэй тэнд ажиллаад л ерөөсөө тэнд нэг жоохон олон жил ажиллалаа, төсөвт өртөг л нэмэгдээд л байдаг болохоос биш ердөө ер нь хийсэн ажил муутай л байх шиг санагдаад байдаг юм. Тийм учраас тэр хүмүүстээ хариуцлага тооцоорой гэж та бүхэнд хэлмээр байна.

Тэгэх дээр энэ хуулиар Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг бас тодорхой хэмжээгээр ингээд л хумслаад аваад явж байгаа гэдгийг бас манай Их Хурлын гишүүд анхаарах ёстой. Үндсэн хуулийн 25 дугаар зүйл ангиар 25 дугаар зүйлээр төсөв батлах, баталсан төсвөө хянах, шалгах ийм үндсэн үүргийг маань энэ хуулиар Засгийн газар луу аваад явчхаж байна. Урьд нь бүүр нийслэл рүү авч явж байсан. Тэгээд тэрнийг нь больж байх шиг байна. Тэгэх дээр төсөв дотор чинь 4 үндсэн бүрэлдэхүүн байдаг юм.

Нэгдүгээрх нь төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, гадаад зээл гээд энэ 4 асуудлыг зохицуулдаг. Гэтэл энийг өнгөрсөн 10 жилийн туршид энэ төсвийн зардлаа замбараагүй болгосны үр дүнд энэ төсөв дотроо ороод шийдээд явдаг байсан энэ зүйлийг маань цаашдаа одоо Их Хурал энэ төсвийн асуудлыг ялангуяа гадаад зээлийн асуудлыг хянах, шийдвэрлэх ийм боломжгүй болгож энэ хуулиараа авч гарч, энэ үндсэн хуулийн асуудал болгож байгаад бас харамсаж байна. Тэгээд нэг нэгээр ингээд л Засгийн газар ингээд л мэрээд л энэ Их Хурлын үндсэн бүрэн бүрэн эрх рүү одоо ингээд халдаад л жоохон энэ төр засгийн энэ татвар төлөгчдийн мөнгийг хэмнэх, хязгаартай хэрэглэх энэ бүх зүйлийг чинь Засгийн газар дураараа шийдэх ийм л боломж руу аваад явж байгаад Их Хурлын гишүүд бас жаахан анхааралтай байгаарай.

Дараа дараагийн ийм асуудал орж ирнэ. Энэ чинь одоо ингээд араасаа дуртай сайд нар нь янз янзын энэ хуулийн дагуу янз янзын өөрсдийнх нь нэг тийм хүслийн хөрөнгө оруулалтыг шийддэг ийм зүйл болж хувиргахгүй байхын тулд анхаарах ёстой шүү. Энэ дээр манай сөрөг хүчнийхэн бас дараа дараагийн ийм юман дээр бол маш хатуу байр суурьтай байх ёстой гэж би хэлмээр байна аа.

**С.Бямбацогт:** Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

**М.Бадамсүрэн:** Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой эрчим хүч, газрын тосоо дотооддоо үйлдвэрлэх 2 төсөл учраас энийг бол одоо дэмжих ёстой гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ дээр бодлогын хувьд бол нэг хэд хэдэн асуудал байна аа. Тухайлбал газрын тосны үйлдвэр ТӨК. Төрийн өмчит үйлдвэр.

Гэтэл бидэнд одоо газрын тосоо олборлох төрийн өмчит олборлолт хайгуулын компани алга аа. Өөрөөр хэлбэл гадаадын компанийн хараат.

Тэгээд энэ асуудлыг би яагаад сайн мэдэж байна гэхээр Дорнод аймгийн Засаг даргаар ажиллахдаа Монгол Улсын нийт газрын тосны 95 хувь нь зөвхөн Дорнод аймгийн нутгаас олборлож байгаа учраас энэнтэй холбоотой харилцааг бас жоохон гадарлана. Тэгэхээр энэ үйлдвэргүй түүхий эдийг яаж хангах гэж байгаа юм бэ гэдэг асуудлыг би 1 дүгээрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас асууя аа. Энэ байнгын хорооны тогтоол 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр гарсан. Энэ тогтоолын 5 дахь заалт дээр үйлдвэрт шаардагдах түүхий тосыг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлэх гээд. Яг энэ чиглэлээр ямар ажил бодлогын яам хэрэгжүүлж байна гэдгийг би 1 дүгээрт асууя аа.

Мөн энэ үйлдвэртээ одоо 2 хөрштэйгөө ер нь яаж хамтарч ажиллах талаар төлөвлөж байгаа юм уу ийм бодлого манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд байгаа юу? Тухайлбал түүхий эдээ хойд хөршөөс авна, эсвэл Казахстанас авна гэсэн юм яриад байгаа. Тэгээд энэ газрын тосыг тээвэрлэнэ гэдэг чинь өөрөө их нарийн технологитой шүү дээ. Ер нь бол газрын тосыг голчлон дамжуулах хоолойгоор тээвэрлэдэг. Авто замаар тээвэрлэнэ гэвэл эсвэл төмөр замаар тээвэрлэнэ гэвэл өртөг маш өндөр эсвэл далайн тээвэр байдаг. Тийм энэ өөрөө энэ технологийн их онцлог сонголттой бүтээгдэхүүн учраас ингээд түүхий нефтээр хангана гэдэг бол өөрөө их том асуудал аа. Тэгэхээр энийг юу гэж үзэж байна? Нөгөө талд нь өмнөд хөршөөс хөршийн компани Петро Чайна Дачин Тамсаг гэдэг компани 2016, 2017 оноос эхлээд ингээд нэмэлт хөрөнгө оруулалт оруулахгүй цооног нэмж өрөмдөхгүйгээс шалтгаалсан ийм олборлолтын хэмжээ бол буурсан, 2 дахин буурсан байгаа. Одоо нэг 500 мянга хүрч байна уу, үгүй юу. Дорноговьд нэг 50 мянган тонныг олборлож байгаа юм. Нийт олборлолтын 5 хувь нь Дорноговьд, 95 хувь нь Дорнодод.

Тэгэхээр энэ гадаадын компанид найдаад ингээд түүхий эдээ болчих байх даа гээд ингээд яваад байх уу? Мөнгө нь байвал мөнгөөр зодож байгаад үйлдвэрийг барьчихаж бол болох юм шиг байгаа юм. Одоо энийгээ харин түүхий тосоо яаж дотоодын эх үүсвэрээр хангах вэ гэдэг асуудал хамгийн чухал. Энэ газрын тос чинь ингээд олборлолт, тээвэрлэлт, боловсруулалт гээд ийм өөрийн технологийн онцлогтой. Энэ үйлдвэр 1.5 сая тонн хүчин чадлаараа бүрэн ажиллаж чадахгүй бол санхүүгийн хувьд алдагдалтай ажиллана. Тийм учраас энэ бол их том асуудал шүү. Тэгэхээр энэ дээр ер нь ямар тооцоолол байгаа вэ? Монгол газрын тос үйлдвэрийн захирал энэ дээр нэг надад хариулт өгөөч ээ.

Өөрөөр хэлбэл одоо дотоодынхоо өөрсдөөс шалтгаалах зүйлээ бүгдийг хийхгүй бол яг одоо гадаадын компани ингээд олборлолтоо нэмнэ гэсэн. Тэгээд тэр үедээ болох байх аа гэдэг ийм бүдүүн баараг байдлаар хандаж бас огт болохгүй. Тийм учраас манай байнгын хороо үйлдвэрт шаарддаг түүхий эдийг дотоодын хүнсээр бүрэн хангах бодлого гэдгийг одоогоос нэг жил хагасын өмнө гаргасан энэ тогтоолыг Засгийн газарт хүргүүлсэн байгаа. Тэгээд би энэний биелэлт ямар байгаа юм гэж бодож байгаа. Энэ дотор яах вэ олон заалт байгаа. Би цаг бага байгаа учраас зөвхөн энийг нь асууж байгаа юм. Тэгэхгүй бол ингээд хонх нь дуугарахаар дамар нь таг, хоёулаа дуугарахаар лам нь таг гэдэг шиг ийм байдал...

**С.Бямбацогт:** Тийм маш чухал асуудал хөндөж байна. Маш тодорхой хариулт өгөх ёстой. Газрын тос боловсруулах үйлдвэрийн өртөг өсөөд, хугацаа

сунжраад байгаа нэг талдаа. Нөгөө талдаа тэгээд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад ортол нөгөө түүхий эд нь байхгүй бол наана чинь ажиллахгүй. Монголчууд бүгдээрээ энэ газрын тос боловсруулах бол бензин шатахуунаа өөрсдөө үйлдвэрлэдэг болохыг олон жил хүсэж ирсэн, одоо ч маш их хүсэж байгаа. Дамдинням сайд хариулъя.

**Г.Дамдинням:** Асуугаасай гэж бодож байсан асуулт асуусанд баярлалаа. 1 дүгээрт газрын тосны үйлдвэрийн түүхий эдийг тасалдуулах ажилд манай Монголын төрийн шат шатын байгууллагууд системтэйгээр ажилласан юм шиг бүүр нэг хорлох гэж байгаа юм шиг ажилласан эсрэг үйлдлүүд зөндөө хийгдсэн байдаг аа. Сум тэр одоо талбай байгаа сум, аймаг, төрийн агентлаг, дээрээс нь Аудитын газар тэгээд одоо дараа нь Сангийн яаманд гээд энэ байна шүү дээ. 1991, 1992 онд байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ 2030, 2031 онд дуусна. Гучаад жил ингээд тамлаад хаячихсан. Одоо бол энэ компанитай маргаантай асуудал ингээд шүүх дээр очоод ингээд бөөн ойлгогдохгүй нэг цасан бөмбөг шиг юм болоод тавигдчихсан ийм байгаа. Газрын тос яривал их олон юм бий. Газрын тосны харилцааг ашигт малтмалын харилцаагаар шийдэж торгосон асуудлууд шүүх дээр очоод нэг ойлгогдохгүй шийдэгдчихсэн. Эсвэл одоо газрын тосны компани энэ ковидын үед асуудал үүсэхэд нь шал эсрэг талд нь гараад шийдчихсэн ийм юмнууд байгаа.

Тэгээд удахгүй одоо Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг дагуулаад бас тогтоолын төсөл энэ олон улсын гэрээ хэлэлцээртэй холбоотой асуудлыг оруулж ирнэ гэж төлөвлөж байгаа. Энхбаяр сайд бас хариулах байх. Ер нь бол түүхий эдтэй холбоотой асуудал бол манай улс 1.2 сая тонн хүртэл түүхий эдийг өөрөө олборлодог байсан бол энэ хөрөнгө оруулагч ААН-тэй хийсэн төрөл бүрийн маргаанаас шалтгаалаад одоо 300 мянга болсон. Тийм учраас бид дунд хугацаандаа ОХУ болон бусад улсууд орнуудаас түүхий тос авчирч энэ үйлдвэрийнхээ түүхий эдийг Монголынхтойгоо хамтруулж хийх ийм төлөвлөлтийг хийгээд ажиллаж байна. Би одоо энэ 11 сар сайдаар ажиллаж байна. Тасралтгүй энэ ажлыг хийгээд явж байгаа.

Дараачийн асуудал бол төрийн өмчит ААН байгуулаад хайгуул судалгаа хийнэ гэдэг бол ний нуугүй хэлэхэд асар үнэтэй тоглоом. Нэг метр нь хамгийн багадаа мянган долларын өрөмдлөг хийдэг юм шүү дээ газрын тос. Дэлхийн хамгийн том уул уурхайн компани газрын тосны дундаж компаниас жижигхэн байдаг. Газрын тос гэдэг бол өөр тоглоом, үнэтэй тоглоом. Хайгуул дээр нь улсын төсөвт татвар төлөгчдийн мөнгөөр хайгуул судалгаа хийнэ гэдэг бол хатуу тоглоом, тун эрсдэлтэй. Тэгээд энэн дээр бол хэрвээ тийм шийдвэр гаргаад явна гэвэл би хэлэх юм мэдэхгүй байна. Хөрөнгө оруулагч ААН-үүдийн эрсдэлийг л хувааж ингэж явахаас өөр хувилбар бол ер нь дэлхийн улс орнууд хэрэгжүүлдэггүй ээ. Энэ бол төсвөө ч улсаа ч бас эрсдэлд оруулах ийм л тоглоом руу явах байх аа. Гэхдээ газрын тос боловсруулах үйлдвэрт энэ жил бас 2 км өрөмдөх ийм төсвийг бид нар бас тавьж өгөөд л ингээд л явж байна. Оролдлого хийгээд л явж байгаа.

**С.Бямбацогт:** Тодруулчихъя Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Би нэг иймэрхүү хариулт өгөх болов уу гэж бодож байсан. Энэ миний хувьд Дорнод аймгийн Засаг даргаар 9 жил ажилласан. Одоогоос 8-9 жилийн өмнө энэ компанийн үйл ажиллагааг 2017 онд нэг 14 хоног, 2018 онд нэг 45 хоногийн хугацаатай зогсоосон. Тэгэхдээ бид Засаг даргад хуулиар олгогдсон эрхийн дагуу Монгол Улсын төрийн хуулийг биелүүлж энийг зогсоосон. Зогсоосны

үр дүнд өнөөдөр энэ компани 200 гаран километр хатуу хучилттай авто замаар тосоод хийж байгаа. Магадгүй миний хувьд аймгийн Засаг дарга байгаагүй байсан энэ зам баригдаж дуусахгүй байх байсан гэж би боддог. Усанд хяналт тавьдаг болсон. Гүний усны ашиглалтад. Одоо 8 жилийн өмнө энэ зогсоосон юм өнөөдөр ямар ч хамаагүй шүү дээ Дамдинням сайд аа. 8 жилийн өмнө зогсоосон юм.

2 дугаарт энэ Ариунзаяа дарга бас байна. Хөдөлмөрийн сайд байсан. Монгол Улсын хуулийг хэрэгжүүлж байгаа. Ер нь бол хөрөнгө оруулагч гадаадын компанид буруу өгөхгүй, бидэнд өөрсөнд байгаа.

**С.Бямбацогт:** Дамдинням сайд хариулъя.

**Г.Дамдинням:** Тийм. Тэгэхээр ер нь бол ингээд байгаа юм. Бид өөрсдөө энэ салбарт тун шинэ учраас дээрээс нь тойрч зугтсаар байгаад асуудлаа шийдээгүйгээс болоод энэ орон нутгийн удирдлагуудыг ч, эсвэл одоо ингээд бусад агентлагуудын дарга нарыг ч буруутгаад байх хэцүү. Тэнд тэгэхдээ буруутгахаас өөр аргагүй бас ганц нэг кэйсүүд байгаа түрүүн би хэллээ. Газрын тосны харилцааг ашигт малтмалын хуулиар аваад торгочихсон, шүүхэд өгчихсөн ийм зовлонтой асуудлууд байдаг юм. Тэгэхээр энэ бүх асуудлуудыг шийдэх хүрээнд Газрын тосны тухай хууль болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг бэлтгээд ер нь дуусаж байна. Ойрын үед засгаар оруулаад тэгээд өргөн барьчих ийм төлөвлөгөөтэй байна. Тэгэхгүй бол бид яг одоогийн байгаа хууль эрх зүйн орчноороо бол энэ асуудлуудыг шийдэж чадахгүй.

Бадамсүрэн гишүүн бол тухайн үед мөрдөгдөж байсан хууль дүрмийг л мөрдүүлээд л ингээд л явсан. Үгүй бол өөр дээр нь бас хариуцлага тооцуулдаг. Гэхдээ энд бас наана цаана ойлголцоод зохицуулахаар болохоор асуудлууд уг нь байсан л харагддаг. Тэгээд одоо хэдүүлээ засахаас өөр гарцгүй л байгаад байна. Том бодлогоо...

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгын урилгаар ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуулийн 1 дүгээр түвшний оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Оюутнууд та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Одоо яг танай салбарын асуудал газрын тостой болох асуудал яригдаж байгаа энэ цаг үед та бүхэн зочилсон байна. Ер нь асуудал хүнд байна, хэцүү байна ер нь болохгүй болчихсон юм байна лээ гээд байх биш тийм ээ. Хамгийн гол нь газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгаад хурдан хугацаанд түүхий эдтэй тостой болмоор байна. Энэ дээр Засгийн газар онцгой анхаарч түүхий эд тостой болох тал дээр их яаралтай бас шийдэл гаргаж ажиллах ёстой шүү. Энэ дээр бас анхааралдаа аваарай.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя.

**Н.Алтаншагай:** Өдрийн мэнд хүргэе. Гадаад зээлийн үр ашиглалыг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Мөн одоо бас 21 гишүүдийн хамт өргөн бариад хэлэлцэгдээд явж байгаад харамсалтай нь өнгөрсөн 7 хоногт энэ хуулийн төсөл маань Их Хурал дээр босго даваагүй унасан. Яаралтайгаар Засгийн газраас яаралтай горимоор оруулж ирээд хэлэлцүүлээд явж байгаагийн хувьд бас талархалтай байна. Тал еэвэнгийн үлгэр шиг юм болсон харамсалтай. Улаанбаатар хотын Сэлбэ дэд төв маань ингээд орхигдоод энэ хуулийн гадна үлдэж байна. Уг нь хамт явсан юм.

Нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Сэлбэ дэд төв гэж яваад ингээд үлдээд энэ хүрээд явж байна аа. Сэлбэ дэд төв маань маш том бүтээн байгуулалт. Улаанбаатар хотод одоо 40, 50 жилийн дараа хийгдэж байгаа ийм томоохон цогцолбор хороолол. МАН-ын мөрийн хөтөлбөр болон энэ шат шатад дэвшүүлэн оролцсон улс төрийн хүчнүүдийн мөрийн хөтөлбөрт байсан. Улаанбаатар хотыг 20 минутын хот гэсэн хөтөлбөрт 14 хотод хуваах хамгийн том анхны эхлэл байсан. Тэгээд харамсалтай нь энэ төсөл маань хуулийн гадна үлдэж байна. Энэ төсөл явснаараа энэ агаар, орчны бохирдол, хөрсний бохирдол, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах гээд олон талын ач холбогдолтой байсан. Энэ Сэлбэ дэд төв энэ хуулийн гадна үлдсэнээрээ эрсдэл үүсэх үү? Энэ маань зогсохгүй цаашаа үргэлжлэх үү?

Би өнгөрсөн амралтын өдөр энэ Сэлбэ дэд төв дээр очиж ажилласан. Гүйцэтгэгч компаниуд тэр талбай дээр ажиллаж байгаа инженер, энэ барилгын ажил албан хаагчтай уулзсан. Хувийн хэвшлийнхэн маань жоохон сэтгэл гундуу байна лээ, сэтгэл дундуур байна лээ. Тухайн бүс нутгийн энэ Чингэлтэй, СБД-ийн нутаг дэвсгэр дээр байгаа оршин сууж байгаа иргэдийн төлөөлөлтэй ч уулзсан. Маш их хүлээлттэй байсан, үнэхээр харамсалтай байгаагаа илэрхийлж байсан. Тэгээд энэ Сэлбэ дэд төв маань эрсдэлгүй цаашаа явах уу? Нийслэл дээр бонд гаргаад 500 сая долларын хөрөнгө босгочихсон энэ нь зарцуулалтын эрхийг нь нийслэлд нь өгөх үү.

Сүүлийн үед энэ улс төржилт хэрээс хэтрээд нийслэл дээр явж байгаа бүтээн байгуулалтын ажлыг Их Хурал дээр оруулж ирж нэг ярьдаг, гоочилдог, шоглодог ийм үзэгдэл газар авсан. Энийгээ больж нэгэнт одоо энэ орон нутаг, нутгийн өөрөө удирдах байгууллагууд холбогдох шийдвэрээ гаргаад хууль дүрмийн хүрээнд Засгийн газраар хэлэлцүүлээд, соёрхон батлуулаад, хэлэлцээр хийлгээд энэ бонд босгочихсон, мөнгө босгочихсон. Энийгээ одоо яг зарцуулах эрх нь тухайн тэр шатын орон нутгийн байгууллагад эрх нь олгогдож байна уу?

**С.Бямбацогт:** Сангийн сайд хариулъя Мэндсайхан сайд.

**З.Мэндсайхан:** Алтаншагай гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ Засгийн газар гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах тухай хуулийг санаачлан оруулж ирсэн байгаа. Гадаад зээлээр хэрэгжиж байгаа манай ашиглагдаагүй байгаа зээлийн бараг 38 хувийг эзэлж байгаа газрын тос, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслүүдийг хугацаанд нь ашиглах, хугацаанд нь ашиглалтад оруулах зээлийнхээ ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэхээр энэ хуулийн зорилго байгаа. Сэлбэ дэд төвийн асуудал бол ерөөсөө нийслэл өөрөө бонд гаргаж санхүүжүүлж байгаа төсөл өө. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа Сэлбэ дэд төвийн төсөл явахгүй байна гэсэн үг биш. Нийслэл өөрөө зардлаа эрэмбэлээд, төслүүдээ эрэмбэлээд энэ төслөө явуулах боломж нь нийслэлд байгаа. Тэгэхээр Сэлбэ дэд төв зогсоно гэсэн ойлголт байхгүй. Зөвхөн тэр босгосон бондынхоо зарцуулалтыг хэрхэн ашиглах вэ, энэ ондоо багтааж ашиглах юм уу тийм ээ, энэ бол нийслэлийн Иргэдийн хуралд өөрт нь эрх нь байгаа асуудал.

**С.Бямбацогт:** Алтаншагай гишүүн тодруулъя.

**Н.Алтаншагай:** Тодруулга яах вэ үг хэлье дээ. Энэ хуулийн гол агуулга нь Монгол Улс өөрөө эрчим хүчээ асуудлаа шийдэх, нефтийн үйлдвэрээ барьж энэ дотоодын нефтийнхээ асуудлыг шийдэх, энэ Эрдэнэбүрэнгийн УЦС бол баруун 5 аймгийг эрчим хүчээр дангаараа бие даан шийдвэрлэх, Монгол Улс өөрөө эрчим хүчин дээрээ бодлого гаргаж үнийн уян хатан байдлаар бас хандах шийдвэрлэх ийм боломж бүрдэж байгаа.

Дээр нь энэ нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноороо дотоодын хэрэгцээний 55 хувийг дангаараа хангах дотоодынхоо. Мөн энэ дээр яг асуудал болоод байгаа энэ үнийн үеийн хатан байдлыг дотооддоо зохицуулж, үүнийг дагасан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үнэ хүртэл буурах ийм бодит нөлөөлөл үзүүлэх ийм үр ашигтай ийм төслүүд байгаа юмаа. Тэгэхээр энэ төслүүд маань цаг хугацаандаа ашиглалтад ороосой гэсэн үүднээс энэ хуулийг өргөн барьсан гэдгийг иргэддээ бас тайлбарлаж хэлэх нь зөв байх. Тэгээд хуулийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна аа.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдын урилгаар Төв аймгийн Сүмбэр сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье ээ. Тэгээд удахгүй сургуулиа төгсөнө. Их дээд сургуульд хүссэн мэргэжлээрээ бас элсээд улс эх орондоо хариуцлагатай, хуулиа дээдэлдэг, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсан иргэн болоорой гэж та бүхэндээ бас хүсье ээ.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

**Л.Соронзонболд:** 2024 онд Улсын Их Хуралд сонгогдоод намар нь болохоор энэ мега төслүүдийн талаар ингээд бүсдээ танилцуулга хийж явж байсан. Тэгээд эдийн засгийн хувьд ашигтай энэ газрын тосны үйлдвэр, баруун бүсийг цахилгаанаар бүрэн хангах боломжтой Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл гээд. Гэтэл яг ингээд тухайн жилийнхээ төсөв дээр хөрөнгө оруулалт дээр тавьж чаддаггүй нэг ийм асуудал байгаад байсан. Тийм учраас энэ гадаад зээлийн ашиглалтыг дэмжих тухай өмнөх төслийг өргөн барихад би өөрөө дэмжиж гарын үсэг зурсан. Сая Засгийн газраас орж ирж байгааг ч гэсэн дэмжиж байгаа. Монгол Улс жилдээ 2 тэрбум долларыг энэ бензин шатахуунд зарцуулж байна аа. Энэнийхээ дор хаяж нэг 50 хувийг нь өөрсдөө дотоодоосоо үйлдвэрлэдэг болох нь бол үнэхээр стратегийн хувьд чухал байгаад байгаа. Харамсалтай нь яах вэ энэ төсөл маань 2017 оноос хойш явсан. 9 дэх жил рүүгээ орж байна. Энийг цаг хугацаанд нь дуусгах нь үнэхээр хэрэгтэй байгаад байгаа юм. Жил ирэх тусам үнэ ханш нэмэгдэж байна. Тийм учраас энэ төслийг би дэмжиж байгаа.

Дээрээс нь болохоор энэ газрын тосны үйлдвэр ашиглалтад ороход энэ түүхий эдийн асуудал үүсдэг. Тэгэхээр энэ газрын тосны хангамжийг нэмэгдүүлэх тал дээр нэлээн ажиллах шаардлагатай байгаад байгаа. Тийм ч учраас зүүн бүс болон говийн бүсийн гишүүдтэйгээ хамтраад энэ Газрын тосны тухай хуулийг өргөн бариад байгаа.

Тэгэхээр Уул уурхайн сайдаас асуух гээд байгаа асуудал маань юу байна гэхээр Дорнод аймгийн Матад сумаас Петро Чайнагийн энэ газрын тосны хоолой

явж байгаа тийм ээ. Энэ хоолойн ажлын бүтээн байгуулалтын ажил маань нэлээн эрчимтэй явж байна гэж харж байгаа. За тэгэхээр үйлдвэр ашиглалтад орсноороо энэ манай энэ газрын тосны хоолойг дамжуулж байгаа энэ ажил чинь өөрөө нийт өртгийн хэдэн хувийг эзлэхээр байгаа юм бэ. Энэ одоо яг зүгээр хоолойг тэгж дамжуулсны гол ач холбогдол нь юунд байсан бэ гэдэг дээр нэг хариулт авъя.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг хариулъя. Индрийн 3 дугаар микрофон.

**Ч.Хишигдалай:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай.

Дэлхийд газрын тосыг тээвэрлэх 4 арга зам байна. Усаар, автомашинаар, төмөр замаар, дамжуулах хоолойгоор. Эдгээр нь хоорондоо ялгагдаж байгаа гол зүйл бол тээврийн зардал аль нь хямдхан бэ гэдэг. Хамгийн хямд зардалтай нь бол усан тээвэрээр тээвэрлэх зардал. Нэг тонн бүтээгдэхүүнийг 100 км тээвэрлэхэд 0.1 цент нэг доллар тээврийн зардал гарч байгаа бол төмөр замаар тээвэрлэхэд 100 км тутамд нэг 10 орчим ам.долларын зардал гарч байна. Дамжуулах хоолой бол үүнээс 2 дахин бага зардлаар тээвэрлэж байгаа. Матад сумаас Дорноговийн Алтанширээ рүү хүргэхэд нэг тонн бүтээгдэхүүнийг 15 орчим ам.доллаароор тээвэрлэх зардлын тооцоо гарсан учраас дамжуулах хоолойн тээвэрлэлтийг сонгосон гэж ойлгосон.

**С.Бямбацогт:** Соронзонболд гишүүн тодруулъя.

**Л.Соронзонболд:** Энэ гадаад зээлийн ашиглалт дээр өмнөх юун дээр яах вэ Сэлбэ дэд төв байсан. Тэгээд би ойлгохдоо Сэлбэ дэд төвийн зээлийг бондыг босгохдоо Сэлбэ төвд төслийг хэрэгжүүлнэ гээд одоо Монгол Улс нийслэл зээл авчихсан. Тэгээд мөнгө нь ороод ирчихсэн байгаад байдаг. Нөгөө зээлээ зориулалтын дагуу ашиглаж чаддаггүй нэг ийм асуудал байгаа юм байна лээ. Тийм учраас энэ асуудлыг шийдэх тал дээр нь бас нэлээн сайн анхаарах ёстой юм байна л гэж бодож байгаа юм. Нөгөө талдаа энэ чинь Монгол Улсын өөрийнх нь нэр хүндийн асуудал шүү дээ тиймээ. Ийм зориулалтаар зээл бонд босгож ашиглана гэххээд тэрийгээ ашиглаж чаддаггүй, хэрэгжүүлж чаддаггүй нэг ийм байдал байгаад байгаа нь бас их учир дутагдалтай байгаа. Тийм учраас шат шатын байгууллагууд энэ дээрээ анхаарах ёстой гэж хэлмээр байгаа юм.

**С.Бямбацогт:** Үг хэлчихлээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя. 12 цаг 30 минутын үед санал хураалттай болно шүү. Гишүүдийг 12 цаг 30 минутын үед санал хураалтдаа чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг бас урьж байна аа.

**М.Энхцэцэг:** Сайн байцаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Гадаад зээлийн энэ хуулийг дэмжиж байгаа. Дөнгөж саяхан би Ховд аймагт баригдаж байгаа Эрдэнэбүрэнгийн УЦС дээр ингээд очоод ирсэн. Одоо бүтээн байгуулалт 24 хувьтай явж байна аа. Тэгээд бид нарын одоо том бүтээн байгуулалтын ажлыг хийхэд гол санхүүжилт маань үнэхээр ерөөсөө л гадаадын зээл байгаа. Гэтэл энэ гадаадын зээлээ бид нар боломжийнхоо хэрээр тухайн богино хугацаанд хэрэглээд, бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд дуусгах шаардлагатай байгаа. Гэтэл энэ гадаад зээлийн тааз тулж байна аа гэдгээр бид нар тухайн зээлийг жил жил жижигхэн жижигхэн одоо нөгөө дусал дуслаар хэрэглэ. Ийм л хуультай. Тэгэхээр энэнээсээ болоод яаж байна гэхээр ерөөсөө тухайн төсөл дуусахгүй цаг хугацаа маш их алддаг. Тэгэхээр цаг хугацаа гэдэг ерөөсөө л мөнгө.

Цаг хугацаа алдах тусам бид нар долларын ханш өсөж байна, одоо ингээд санхүүжилт өсөж байна, хөрөнгө оруулалт өснө гээд асар олон хохирлыг бид нарт авчирдаг. Тийм учраас энэ хуулийг дэмжээд бид нар тэр одоо том бүтээн байгуулалтын ажлуудаа дуусгах зайлшгүй шаардлагатай байгаа.

2 дугаар асуудал болохоор өмнөх орж ирсэн хууль дээр Сэлбийн бүтээн байгуулалтын ажил орж ирсэн байсан. Одоо ингээд хасагдчихсан байна аа. Тэгэхээр бид нар бас энэ Сэлбийг чухам яагаад хасагдчихав аа? Уул нь энэ Сэлбийн бараг 3, 4 дүгээр хорооллоос том хэмжээний ийм том бүтээн байгуулалтын барилгажилтын ажил, тэр сургуультайгаа, цэцэрлэгтэй ийм том ийм бүтээн байгуулалт маань хороолол маань хурдан хугацаанд л орж байвал ядаж тэр нөгөө байшин барилга нь, орон сууц нь зарагдах үнэ ханш нь арай хямд байна биз дээ. Тэгэхгүй одоо дахиад л тэр нөгөө зээл гадаадын зээллэг гэж байгаа. Бас л ингээд ашиглах боломжийг нь хязгаарлачихаар энэ бүтээн байгуулалт мөд дуусахгүй. Тэгэхээр мөд дуусахгүй гэдэг маань  $1\text{м}^2$ -ын байшингийн үнэ өснө өө л гэсэн үг. Товч бөгөөд тодорхой. Тэгэхээр энэ чухам яагаад бас хасагдчихав аа? Энэ дээр бас хариулт өгөөч ээ. Ялгаа нь бид нар нөгөө байнгын хороон дээр асууж байхаар энэ юу Эгийн гол болохоор зээл юм байгаа юм, нөгөөх нь зээллэг юм байгаа юм гэхэд зээллэг ч гэсэн адилхан гадаа олон улсад бонд гаргасан ийм асуудал. Тэгээд энэ маань дахиад л нөгөө хязгаарлалтад орчихоор энэ бүтээн байгуулалт дуусах хугацаа нь уртсах юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бас нэг хариулт өгөөч ээ. Бусдаар бол энэ хуулийг дэмжиж байгаа.

**С.Бямбацогт:** Сангийн сайд хариулт өгье.

**3.Мэндсайхан:** Энхцэцэг гишүүний асуултад хариулт өгье. Гадаад зээлийн тааз тулсан асуудал байхгүй ээ. Гадаад зээлийг авч ашиглах төсвийн хязгаар нь хязгаарлагдмал байгаа шүү. Түүнээс биш манай гадаад зээлийн тааз бол цаана нь хуулиараа 20 хувийн орон зай байж байгаа. Одоо бид нар хуулиар олгогдсоноосоо 40 хувийг нь ашиглаад явж байгаа. ДНБ-ий 40 хувьтай тэнцэхийг нь ашиглаад явж байна. Хуулиараа бид нар 60 хүртэл ашиглах боломж нь байгаа. Тэгэхээр гадаад зээлийн тааз бол тулаагүй.

Сэлбэ дэд төвийг зогсоож байгаа асуудал огт биш шүү. Энэ зүгээр Сэлбэ төв дэд төв бол нийслэл өөрөө орон сууцны төсөл хэрэгжүүлэхээр босгосон бондын асуудал байгаа. Энэ орж ирж байгаа хууль бол гадаадаас бид нар ОУБ-аас Монгол Улсын Засгийн газар үүрэг хүлээгээд авчихсан зээлийн харилцаанд явж байгаа 2 төслийг бид нар бас оруулж ирж байгаа. Нийслэл өөрөө Иргэдийн хурал нь шийдвэрээ гаргаад, зардлаа эрэмбэлээд Сэлбэ төслийг явуулах тэр эрх нь нийслэлдээ байгаа. Энэ зогсоож байгаа асуудал огт биш шүү. Нийслэл өөрөө зардлаа эрэмбэлээд, төслөө эрэмбэлээд аль төслөө нэн яаралтай явуулах юм. Сэлбэ дэд төвөө явуулах юм уу. Ингээд Иргэдийн хурлаараа шийдээд л явчих асуудал. Түүнээс биш энэ зогсоож байгаа асуудал огт биш шүү.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургуулийн 12-ын “д” ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ. Тэгээд удахгүй дунд сургуулиа төгсөөд бас хүссэн сургуульдаа, хүссэн мэргэжлээ сурч эзэмшээд эх орондоо ихийг

хийж бүтээсэн хариуцлагатай хуулиа дээдэлдэг иргэн болж төлөвшихийг та бүхнээс хүсье. Манай гишүүд маань танхимд цөөхөн байгаа нь өрөөндөө бас ажлаа хийж байгаа шүү бас зөв ойлгоорой та бүхэн.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

**А.Ариунзаяа:** Би асуулт асуухгүй, үг хэлчихье. Хариулт нь угаасаа ямар гэхийг би мэдэх учраас асуулт бол асуухгүй ээ. Монгол Улс яг гадаадын зээл тусламж аваад 74 төсөл 13.8 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Тэгээд энийгээ зарцуулахгүй байгаа. 1.3 их наяд төгрөгөөр зээлийн ашиглалт энэ жилийнх шигээ явах юм бол эдгээр төслүүд хэрэгжих хугацаа нь 5-10 жилээр хойшилно. Зардал нь мэдээж нэмэгдэнэ. Хүүгийн төлбөр болон зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэнэ. Төслүүдийн үр өгөөж мөн түүнчлэн эдийн засгийн үр ашгийг хүртэх хугацаа бол яах нь вэ хойшлох нь байна шүү дээ.

Тэгээд яагаад ийм нөхцөл байдал үүсчих вэ гэхлээр нь өрийн таазтай огт холбоогүй хүмүүс хэлээд байна шүү дээ. Өрийн тааз бол одоо өр авах, зээл авах тийм ээ энэ орон зай байгаа. Бид нар авч болно. Ецге ч одоо нэмэгдүүлээд авч болно. Гагцхүү Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал эс үгүй бол одоо ашиг 2 хувьтай тэнцэнэ гээд хуульчлаад өгчихсэн. Энэ юу гэсэн үг юм бэ гэхээр төсвийн нэгдсэн орлого нэгдсэн төсвийн зарлага хоорондоо хоёрхон хувийн зөрүүтэй байж болно оо гэсэн үг. Ашигтай, эс үгүй бол алдагдалтай. Тэгээд энэндээ баригдаад урсгал зардал, цалин хөлс бусад энэ бүхий л энэ зарлагын хэмжээ чинь өндөр байгаад байгаа учраас үлдсэн жоохон тэр орон зайн дээрээ суурилагад энэ зээл ашиглалтаа оруулаад байгаа байхгүй юу. Тэгээд одоо энэ хууль юу вэ гэхлээр хүүхэд хуурч байгаа юм шиг энэ 2 төсөл бол энэ хязгаарт орохгүй шүү гэххэж байгаа юм. Яаж байна аа гэхлээр үндсэндээ би нуугдчихсан шүү, би байхгүй шүү. Энэ 2 төслийг харахгүй шүү.

Энэ 2 төслийг энэ төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээнд тооцохгүй гэххэж байгаа юм. Ямар ялгаатай юм? тэгээд яагаад энэ 2 төсөл юм.

Үндсэн хуулийн 5.4 дээр суурилагад төр нь үндэсний аюул эдийн засгийн аюулгүй байдалд аж ахуй бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна аа гэж байгаа юм. Тэгээд хүн амын нийгмийн хөгжил нь тэгээд яах вэ? Бусад төслүүд нь тэгээд яах вэ гэсэн ийм асуудал үүснэ биз дээ? Тэгээд би юу хэлээд байна вэ гэхлээр өөрийн өөртөө тавьсан энэ чөдөр тушаагаа больчхооч ээ. Тэр 2 хувьд багтаана аа гэдэг энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-өө өөрчилье өө. 2017 онд энэ чинь 10 хувь байсан юм. 10.4 хувь байсан юм.

Тэгээд одоо ингээд чөдөрлөсөөр байгаад 2 хувь, 2 хувиас илүүгүй байна аа гээд л оруулчихсан шүү дээ. Тэгээд өөрсдийгөө хуураад энэ 2 төслийг энэ нийт энэ тооцоонд оруулахгүй шүү гээд л бид нар өөрсдөө ийм юм оруулчхаж байгаа байхгүй юу. Ямар ялгаатай юм. Адилхан авсан зээл шүү дээ. Зүгээр энэ хязгаараа л больчих л доо. Алдагдалгүй төсөв гэдэг юм чинь үнэхээрийн етоп гэдгийгээ хэлсэн шүү дээ. Тэгээд одоо яах юм Ерөнхийлөгч өө. Энэ 2 төслийг тооцохгүй шүү гээд явах уу. 2027 онд 4.5 их наядын 3 төсөл зээл нь хэлэлцээртээ ороод явчихсан байгаа. Тэгээд ийм л юм болоод байна найзууд аа. Тэгээд одоо өөрөө өөрсдийгөө хуураад, өөрөө өөрсдийнхөө чөдөр тушаагаа л авчихмаар байх юм.

Төсвийн тогтвортой байдлын хуулийнхаа 19.9-ийг өөрчлөх хэрэгтэй. Алдагдалгүй төсөв гэж энэ балай юмаа ярьдгаа болих хэрэгтэй. Нэгэнтээ зээлүүдээ авчихсан юм бол түүнийгээ ашиглах хэрэгтэй. Өнөөдрийн үнийн өсөлт ямар байгаа билээ. Тэгээд ингээд нэг ийм юм ярихлаар Ариунзаяа чи ийм хариуцлагагүй мэдэгдэл хийлээ гээд ингээд нэг уурлаад байхлаар би өчигдөр, уржигдар бас бухимдаж нэлээдгүй үг хэлсэн. Тэгээд энийгээ л Засгийн газар маань өөрчлөөсэй л гэж хүсэж байна.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Г.Ганбаатар:** Энэ гадаад зээлийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хуулийн төслийг түрүү 7 хоногт Улсын Их Хурлаар орж ирэхэд нь миний хувьд дэмжээгүй. Яагаад дэмжээгүй вэ гэхлээр мэдээж хэн ч гэсэн нутаг орондоо ялангуяа Дорноговь аймгийн Алтанширээт дээрээс нь газрын тостой, эрчим хүчтэй болохыг хэн ч хүсэхгүй хүн гэж монгол хүн гэж байхгүй. Энэ бол монголчуудын нэн тэргүүний сонирхол. Гэхдээ яагаад дэмжээгүй гэхлээр нийслэлийн бондоор 500 сая долларын бонд босгочихсон мөртөө барилга барьж байхад дахиад ийм тусгай хууль гаргах гээд дагалдуулаад 500, нийслэлийн 500 сая долларын бонд орж ирсэн учраас дэмжээгүй юмаа. Тэгээд ч одоо өнөөдөр яах вэ Засгийн газар өөрөө өргөн барьж байна. Сэлбэ дэд бүтцийн тэр барилгажуулах асуудлыг нь хасаад. Юмаа хэдүүлээ бас ойлгож ялгаж салгахгүй бол энэ чинь болохгүй л дээ.

Нэг нь гадаадын зээл, нөгөөдөх нь нийслэлийн бонд хоёроо холиод. Яг тэр үеэр чинь яагаад энэ ороод ирсэн гэхлээр АН-ын их хурал болж байсан. 2 өдөр хуралдсан. Үндэсний бодлогын хорооны хурал нь нэг өдөр хуралдсан. Үндсэндээ 3 өдөр хуралдаж байхад тэр хойгуур энэ Сэлбэ дэд бүтцийн асуудал ороод ирсэн байсан шүү дээ. Тийм ч учраас АН-ын бүлэг дургүйцсэн байх. Бас унасан шалтгаан нь тэр хуралдаан болж байхад Засгийн газрын гишүүд өөрсдөө саналаа өгөхгүй унагасан шүү дээ. Тэгээд юм л бол одоо Улсын Их Хурал эсвэл муу л бол хойд овоохой гэдэг чинь АН руу буруутгаад пиар яваад байгаа харагдсан. Үүнийгээ цаашдаа бас болих хэрэгтэй.

Ер нь бол яах вэ энэ хөгжлийн томоохон төслүүдийг чинь бид нар уг нь Хөгжлийн банкныг л санхүүжүүлэх гэж Хөгжлийн банкныг ингэж л байгуулсан юм. Харамсалтай нь Хөгжлийн банкаа тоноод дуусчихсан, нэр хүндгүй болгочихсон учраас ингээд нэг ийм гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах нэг удаагийн хууль эд нар л оруулж ирж байна.

Асуултын хувьд энэ газрын тосны боловсруулах Монгол газрын тос байх аа. Боловсруулалтын 2017 оны 4 сард байгуулагдсан шиг санаж байна Засгийн газрын тогтоол гарч 9 жил боллоо. Энэ хайгуул үйлдвэр байгуулж эхлэх цагаас нь манай нутгийн бас том эдийн засагч Ерөнхий сайд байсан хүн Думаагийн Содном гуай тухайн үед Өдрийн сонин дээр гарч байсан даа. Дорноговьд хуурай худаг ухаад байна гэдэг ярилцлага. Одоо түүхий эдээ яах билээ? Өчнөөн өр зээл тавиад нэг 9, 10 жилийн дараа нэг үйлдвэртэй болдог юм байж. Түүхий эдээ яах вэ. Гэрээнүүд хийгдэж байгаа юу? Тээвэр ложистикийнхоо асуудлыг шийдэж байгаа юу? Давхар хайгуулууд явж байгаа юу? Намайг Дорноговьд ажиллаж байхад 6, 7 компани хайгуулын ажил хийдэг байсан. Хятад улсын Голден Сигээс тэргүүлээд одоо хайгуулууд газрын тосон дээр хийгдэж байна уу?

Хоёр дахь асуудал нь, 2 дахь асуулт нь анх энэ чинь нөгөө Энэтхэгийн тэрбум зээл гээд түрүүн Сангийн сайд зөв л хэлээд байна лээ л дээ. Манайх юунд ашиглах вэ гэж байгаад 1.2 анхных нь ТЭЗҮ 1.2 тэрбумаар хийгдээд нөгөө Энэтхэгийн зээлийг аваад сүүлдээ 236 сая доллар нэмээд дараа нь өнгөрсөн жилийн 1 дүгээр сард байх аа бид нар чинь нэг 462 сая долларын зээлийн эрх нэмж олгосон. ТЭЗҮ нь 38 хувь нэмэгдсэн. Ер нь аливаа ТЭЗҮ хийгдэхдээ бүх зүйл орж байж хийгдэх ёстой. Гэтэл энэ дотор чинь нөгөө Норинко интернэйшнлийн 388 сая доллароор барьсан 530 км хоолойны ТЭЗҮ нь ороогүй шүү дээ.

Дээрээс нь Хөгжлийн банкнаас дэд бүтцийнх нь асуудалд зарцуулсан олон тэрбум төгрөг Монголын талаас гаргасан бас ороогүй. Яг үндсэндээ энэ үйлдвэр чинь миний тооцож байгаа ерөнхий тооцоогоор 2.2 тэрбум доллар хүрчхээд явж байгаа шүү. Асар их мөнгө шүү. Энэ хэрвээ ямарваа нэгэн байдлаар түүхий эдийн нөөцөөс юм уу, ямарваа нэгэн байдлаар фэйлдэх юм бол манай улсын эдийн засагт төсөв дээр асар их дарамт үүснэ ээ. Тэгээд энэ асуудлуудаа яаж шийдэж байгаа вэ гэж.

Гурав дахь асуудал нь ер нь газрын тосны энэ үйлдвэр дээр нэг алдаа гарсан. Санхүүжилт, гүйцэтгэл, хяналт 3 нь 1 сагсанд байсан нь том алдаа болсон. Цаашдаа энэ газрын тосны...

**С.Бямбацогт:** Гүйцээгээд асуучихъя. Гомбын Ганбаатар гишүүн.

**Г.Ганбаатар:** Цаашдаа хувь гишүүний хувьд газрын тосны энэ үйлдвэр барих санхүүжилт дээр олон улсын нэр хүнд бүхий аудит оруулах саналтай байгаа. Зөвхөн 1.2 тэрбумаар гэж анх ярьж байгаад ахиад 38 хувь буюу 462 сая доллароор өссөн. Тэгээд бусад зардлыг нь би тооцоод 2.2 тэрбум хүрчхээд байна аа гэж хэлж байгаа юм. Үүн дээр хариултаа авъя. Сангийн сайд, Эрдэс баялаг, аж үйлдвэрийн сайд 2-оос.

**С.Бямбацогт:** Дамдинням сайд эхлээд хариулъя.

**Г.Дамдинням:** Газрын тосны үйлдвэрийн түүхий эдтэй холбоотой асуудал бол маш их яригдаж байна аа. Газрын тосны үйлдвэрийн түүхий эдтэй холбоотой асуудлыг бол бид бас түрүүн хэлсэн. Ер нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, газрын тос хариуцаж байгаа төрийн байгууллагуудаас энэ хайгуул судалгаан дээр талбай өгье гэж бүх талаар бүх хайгуул хийдэг компаниудад мэдээлэл хүргүүлж, урьж ингэж ажиллаж байгаа.

Түрүүн таны дурдсан ААН гэхэд талбайгаа авчхаад Жавхлан сайд аа, талбайгаа авчхаад, хайгуулаа хийхгүй бүтээгдэхүүн хуваах гэрээгээ больё оо гээд ингээд алга болчихсон ингээд байж байгаа. Одоогийн байдлаар бол манай улс газрын тосны хайгуулын 9, уламжлалт бус газрын тосны 8 хайгуулын тусгай зөвшөөрөл эндээс бол газрын тосны ашиглалтын 4 талбайд хайгуул хийж байна. Одоо хүлээгээд авчихсан байна. Геологийн нөөц 333.7 сая тонн үүнээс 44.5 сая тонн нь бол олборлох боломжтой. Эдийн засгийн ач холбогдолтой нөөц байна. Одоогийн байдлаар бол 12.1 сая тонн газрын тосыг олборлож, орон нутгийн төсөвт 2.8 их наяд төгрөгийн орлого оруулсан байна газрын тосны салбараас. Баталгаат нөөц үндсэндээ цаана нь 32.4 сая тонн байна. Одоогийн байгаа олборлогч ААН-үүдтэй эрэл судалгааны ажлыг нь нэмэгдүүлэх чиглэл байнгын хэлцэл хийж байна.

Би түрүүн бас хариултдаа тодорхой хэлсэн. Төрөл бүрийн хуулийг цаг тухай үед нь бас янз янзаар ашигласнаас шалтгаалж эрэл судалгааны ажлыг бол туйлын хүнд байдал руу оруулчихсан байгаа. Ойрын үед Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуультай хамт энэ асуудлыг нэг мөр шийдэх хуулийн төсөл орж ирнэ. Ингээд энэ Петро Чайна компанийн хувьд бол танай газрын тосны үйлдвэрийн түүхий эдийг хангах эрэл судалгааны олборлолтын ажлыг бид ойрын хугацаанд хийж чадна аа гэдэг амлалтаа өгөөд байгаа. Мөн бас бид энэ үйлдвэрийнхээ түүхий эдийг хоёрдогч эх үүсвэр буюу бас ОХУ болон бусад улс орнуудаас газрын тосоор дунд хугацаандаа хангадаг болох ийм төлөвлөгөөг хийж, өндөр дээд түвшний айлчлал мөн сайд нарын түвшний ажлын айлчлалын хүрээнд урьдчилсан хэлэлцээ яриа хөөрөөг хийгээд ингээд явж байна. Үр дүнд хүргэнэ ээ.

**С.Бямбацогт:** За үнэхээр газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэртэй болчхоод тосгүй, түүхий эдгүй байвал үнэхээр эмгэнэлтэй л юм болно. Тийм болохоор үнэхээр анхаарах ёстой асуудал шүү. Сангийн сайд хариулъя. Зээл өсөж байгаа 1.2 тэрбум байсан 500-гаад саяар өссөн дээрээс нь сая доллароор тэгээд 2.2 тэрбум доллар болох гээд байгаа. Энэ дээр аудит хийх боломж үнэхээр ингэж үндэслэлтэй байгаа юу бас.

**З.Мэндсайхан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам төсөл гүйцэтгэлийн болон нийслэлийн аудитаа хийгээд явж байгаа төсөл дээр. Ер нь Ганбаатар гишүүн таны хэлж байгаа үнэн л дээ. 1 аравны энэ чинь нөгөө 1 их наяд тэрбум долларын хөнгөлөлттэй зээл гээд зээлийн зарцуулга зориулалт нь эхэндээ тодорхойгүй байж байгаад газрын тосны үйлдвэр барихаар шийдвэр гарсан. Ингээд урьдчилсан ТЭЗҮ-гээрээ 1.2 болоод ТЭЗҮ нь бүрэн боловсруулагдаад дуусахад 464 сая доллар дахиж нэмэгдсэн. Энийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд батлаад явуулсан байгаа. Ингээд нийтдээ 1.7 их наяд болсон хөрөнгө оруулалт нь. Эрдэнэс Тавантолгой газрын тос дамжуулах хоолойг 397 сая доллароор хийж байгаа. Ингээд нийт төсөвт өртөг бол 2 их наяд 195 сая доллар болж байгаа төсөвт өртөг нь.

**С.Бямбацогт:** 2 тэрбум 195 сая тийм үү. 2.2 тэрбум доллар гэсэн үг шүү дээ тийм ээ. Маш их мөнгө, маш том мөнгө тийм үү? тодруулъя Ганбаатар гишүүн.

**Г.Ганбаатар:** Ганц тодруулга байна. Ер нь яг 2.2 тэрбум доллар болчхоод байгаа байхгүй юу. Бид нар чинь анх 1 тэрбум долларын зээл ярьсан, дараа нь 1.2 болсон. 1.7 болсон ингэсээр байгаад одоо энэ чинь нөгөө 2017 оноос хойш 9 жил болчихлоо. Зээлийн хүүгээ төлөөд эхэлчихсэн. Одоо яг зээлийн хүүд баригдаагүй байгаа энэ үйлдвэрийн зээлийн хүүд хэдэн сая доллар төлчхөөд байна.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг хариулах уу? Сангийн яамнаас. Индрийн 3 дугаар микрофон Тулга дарга хариулъя.

**С.Тулга:** Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар Тулга байна. Энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд ер нь бол гадаад зээлийг хүүн дээр яг ашигласан дүнгээрээ хүү төлөөд явж байгаа. Тэгээд ашигласан дүнгээр газрын тос боловсруулах үйлдвэр дээр 12.4 сая ам.долларын хүү гэж төлсөн байгаа. Ашиглагдаагүй үлдэгдэл буюу одоо нөгөө хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр дээр ерөнхийдөө бас төлбөр төлдөг байгаа. Тэгээд нийт бид хэд 50 орчим

тэрбум төгрөгийн ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр энэ нөхөн төлбөр төлж байна. Үүний хагас нь газрын тос боловсруулах үйлдвэр дээр төлж байгаа.

**С.Бямбацогт:** Зээлээ хурдан ашиглахгүй бол ашигласан, ашиглаагүй бас зээлийн хүү төлөөд яваад байгаа юм байна шүү дээ тийм ээ. Тийм хурдан ашиглаж үр өгөөжийг нь хурдан гаргах шаардлагатай байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо дэмжсэн, дэмжээгүй хуулийн төслийн талаар байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үгээ хэлнэ үү? Цэвэгдоржийн Туваан гишүүн үгээ хэлье.

**Ц.Туваан:** Дэмжиж үг хэлнэ. Энэ асуудал маань бас унаад тийм ээ бас дахиад яаралтай горимоор хэлэлцэгдэхээр орж ирээд гишүүдийн санал аваад ингээд хэлэлцэгдэж байгаа. Тэгэхээр энэ яаралтай хэлэлцэхгүй бол бид нар бас болохгүй байгаа юмаа. Энэ дээр ерөөсөө энэ газрын тос боловсруулах үйлдвэр маань ингээд яг одоо технологийн өндөр технологи шаардсан тоног төхөөрөмж буюу хамгийн их мөнгө орох хэсэг дээр ирчхээд байгаа юм. Тэгээд яг энэ үед нь болохоор нөгөө манай бас л нөгөө хууль тогтоомжийн дагуу нөгөө гадаадынхаа байгаа зээлээ ашиглаж чадахгүйгээр тэр дарга нь яриад байгаа шүү дээ. Бүүр удаан хугацаанд юм явах нь ээ гээд. Тэгэхээр энийг яаралтай хэдүүлээ энэ хуулийг баталж гаргаж өгөхгүй бол маш том гацаа үүсээд байгаа.

Бид нар энэ одоо бол мэдэж байгаа шүү дээ. Дизель түлш 4350 төгрөгөөр нэг литрийг нь хэрэглэж байна. 2900 л байсан маш 50 хувь нэмэгдчихээд явж байна. Тэгэхээр энэ нөхцөл байдлаас гарах нэг арга бол бид нар бусдаас хараат бус өөрсдийн газрын тос боловсруулах үйлдвэртэй болох л асуудал. Жилдээ бараг 2 тэрбум гаруй америк долларыг бид нар гадагшаа нефть бүтээгдэхүүн газрын тосны бүтээгдэхүүн худалдаж авахад зарцуулаад байгаа. Тэгэхээр энэ бол гадаад худалдааны тэнцэл дээр ч гэсэн маш ийм сөрөг ийм зүйл ээ. Тэгэхээр энэнийг манай гишүүд бас дэмжиж өгөөсэй гэж ингэж хүсэж байна.

2 дахь нь энэ Эрдэнэбүрэнгийн УЦС бас мега төсөлд ороод асуудлууд нь бүгд шийдэгдсэн. Улсын Их Хурлын дарга Бямбацогт дарга бас засагт байхаасаа эхлээд орон нутгаас маш их дэмжээд одоо ингээд асуудлууд нь шийдэгдээд явж байгаа тийм ээ. Одоо манай Улсын Их Хурлын гишүүд хүртэл газар дээр нь очоод ингээд явж байгаа. Тэгэхээр энэ явж байгаа төслөө бас л зогсоочихгүй явахгүй бол энэ өөрөө 90 мвт-ын УЦС баруун бүс нутагт бид нар дор хаяж 150-200 мвт-ын эрчим хүчийг тэнд үйлдвэрлэж байж тэнд уул уурхайн үйлдвэрлэл бусад үйлдвэрлэл явуулахад хүрэлцэхээр байгаа.

Тэгэхээр нэлээн тийм зайлшгүй аминд тулсан ийм асуудал. Бид нар дахиад энэ өвөл эрчим хүчин дээрээ яалаа бүүр сүүлийн хэдэн жил бараг мартчихсан байсан тог юуны тасалж хуваариар энэ тэр орон сууцуудад хүртэл өгсөн шүү дээ. Тэгэхээр ийм асуудлууд байгаа юмаа. Тэгэхээр манайхан энэ дээр бас дэмжиж өгөөд, хэдүүлээ энийг нь бас явуулаад эрчим хүч, газрын тостой холбоотой асуудал дээрээ бас нэг гарц гаргалгаа гаргая аа. Нэг гэгээтэй зүйл хийе. Тэгэхгүй бол одоо энэ дизелийн түлшний үнэ нэмэгдсэнээс болоод бид нар нөгөө муу гарын ая даадгаар нь уул уурхайн компаниудыг юм ярихгүй байгаа юм. Уул уурхайн олборлолт хийж байгаа дээрээс нь тэр тээвэр хийж байгаа, зөөж байгаа бүх компаниуд дизель машинаар явдаг. Тэгээд энэний үнэ чинь эргээд үнийн өсөлт

болж орж ирээд эргээд бидний төсөв рүү оруулах гэж байгаа мөнгөнөөс багасаж л орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ энэ тэр дээр хэдүүлээ бас бодолцоод энэ хуулийг яаралтай баталж өгье өө.

Тэгээд ер нь бол цаашдаа энэ гадаад гаднын зээлийн мэдээж энэ гишүүдийн хэлж байгаа хяналттай холбоотой асуудлыг нь маш сайн авч үзэх хэрэгтэй байх. Харин энэ ашиглалт дээр энэ төсвийн хууль дээр юм уу, ямар хууль дээр энэ зайлшгүй дахиж нэмж хууль баталж байж гаргах энэ гацааг нь арилгаж өгье өө гэсэн ийм зүйлийг хэлье. Тэгээд дэмжиж байгаа юм.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар “YES Mongolia” ТББ-ын боловсролын хорооны салбар зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Тэгээд Төрийн ордонтой Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Одоо нэг гишүүний дараа санал хураалт болно. Гадуур байгаа гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирж санал хураалтдаа оролцохыг урьж байна аа. Гомбын Ганбаатар гишүүн үгээ хэлнэ үү?

**Г.Ганбаатар:** Би түрүүнд үг саналаа хэлчихсэн шүү дээ. Түрүүнд би нөгөө асуулт байхдаа ерөнхийдөө бас энэ нутгийн хүний хувьд Дорноговь аймгийн Алтанширээ дээр энэ газрын тос барих явцад ямар хүндрэл гараад байгаа, цаашид юу анхаарах вэ гэдгийгээ хэлсэн. Гэхдээ үнэхээрийн цаашид анхаарах гол зүйл энэ нутгийн хүмүүс ч ярьсан, одоо гишүүд маань ч бас ярьж байна. Хуурай худаг ухаад байна шүү, энэ түүхий эдийнхээ асуудлыг шийдээрэй гэдэг асуудал байгаа. Монголчууд монгол компаниуд гаднын хөрөнгө оруулагчид бас газрын тосныхоо хайгуулыг идэвхжүүлэх асуудал байгаа.

Дээрээс нь газрын тосны үйлдвэр ашиглалтад орлоо гэхэд ОХУ Казахстан улстайгаа эртхэнээс гэрээгээ хийгээд тээвэр ложистик энэ бусад асуудлуудаа шийдэх асуудал байгаа. Орон нутгаас хүмүүсээ сургах бэлтгэх асуудлууд байгаа. Энэ бүгд дээр бид өнөөдөр хангалттай ярилцлаа гэж бодож байна. Энэ бүгдийг цаашдаа анхаараарай гэж хэлэх байна аа.

**С.Бямбацогт:** Гишүүд үг хэлж дууслаа. Гадаад зээлийн ашиглалтын ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа. Тэгээд санал хураалтдаа гишүүдийг бэлдэхийг хүсье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Сая сүүлд орж ирсэн гишүүд хурууны хээгээ уншуулж санал хураалтдаа бэлтгэлээ хангаарай. Бүртгэлийн санал хураалт явуулъя, хурууны бүртгэлийн ирцийн санал хураалт. Энэ ирцэд ороогүй татгалзсан гишүүд чуулганы танхимд байхгүй байна гэсэн үг шүү. Байгаад тэгээд ирцдээ орцгооно шүү. Булгантуяа гишүүн суудлаа эзэлье.

Санал хураалтаа явуулъя.

Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Алтангэрэл гишүүн суудалдаа суучих үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор Лувсанжамц гишүүн санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 75.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

12.42 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

### ***Хуулийн төслүүдийн эцсийн найруулга сонсох***

Хуулийн төслүүдийн эцсийн найруулга сонсоно. Ирэх 7 хоногт гишүүд нэлээн өндөр ачаалалтай бас ажиллахаар байгаа шүү. Маш олон хэлэлцэх асуудалтай байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг холбогдох байнгын хороо бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна аа.

1.Шинжлэх ухаан технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо, эцсийн найруулга сонссонд тооцлоо.

3.ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо эцсийн найруулгыг.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Ирэх 7 хоногт нэлээн олон чухал хуулиудыг хэлэлцэнэ. Нэлээн өндөр ачаалалтай хуралдана. Байнгын хороо, чуулган, гишүүдийг бас чуулган, байнгын хороодын хуралдаанд идэвхтэй оролцохыг одооноос ажлаа төлөвлөж, зохион байгуулахыг бас хүсэж байна аа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Зочин танилцуулчихъя. Зочин танилцуулаад өндөрлөө. Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдоржийн урилгаар БЗД-ийн АН-ын хорооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Парламент 5 нам суудалтай байгаа түүнээс хамгийн том сөрөг хүчин бол 42 суудалтай АН-ын бүлгийнхэн энэ баруун гар талд суудаг юм шүү. Тэгээд та бүхэн бас танилцаад аваарай. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Чуулганы хуралдаан хааж байгаа учраас гишүүд танхимд бас цөөхөн байгааг та бүхэн харж байгаа байх.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

12.45 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*